


## НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

### “ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ”

ОНХС-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨЛӨВЛӨХ, ЭРЭМБЭЛЭХ,  
БАТЛАХ ҮЕ ШАТНЫ АЖЛУУДЫГ ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС  
ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГО ХАНГАГДААГҮЙ БАЙНА.

Аудитын код: ДГА-2020/07-НА



|  |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                  |
|--|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  | <p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа<br/> Утас: 70522734    Цахим хаяг: <a href="mailto:dornogovi@audit.gov.mn">dornogovi@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ч.Хэрлэнчимэг<br/> Утас: 70523020    Цахим хаяг: <a href="mailto:kherlenchimegch@audit.gov.mn">kherlenchimegch@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор:        Э.Энхцэцэг<br/>                                          Цахим хаяг: <a href="mailto:enkhtsetsege@audit.gov.mn">enkhtsetsege@audit.gov.mn</a></p> <p>Аудитор:                Л.Равдандорж<br/>                                          Цахим хаяг: <a href="mailto:ravdandorjl@audit.gov.mn">ravdandorjl@audit.gov.mn</a></p> |
|--|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

2020 оны 11 сар

## АГУУЛГА

|                                                                            |     |
|----------------------------------------------------------------------------|-----|
| Товчилсон үгийн тайлбар                                                    | 4-5 |
| Хүснэгтийн товъёог                                                         | 6   |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл ..... | 7-8 |

**БҮЛЭГ 1. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, орлого бүрдүүлэлтэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.**

**1.2. Аймаг, ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, бүрдүүлэлтэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.**

1.2.1. Аймгийн ОНХС-ийн гадаад, дотоод хандив, тусламжийн эх үүсвэрийг боломжит хэмжээнд төлөвлөөгүй байна. 9-10

1.2.2. ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлэхэд ОН-аас мэдээлэл солилцож, оролцоог хангах асуудал орхигдсон байна. 10-12

1.2.3. Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан байна. 12-13

**БҮЛЭГ 2. ОНХС-ийн үйл ажиллагааны төлөвлөлт хангалтгүй хийгдэж байгаагаас сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй байна.**

**2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-г олон нийтийн оролцоотой төлөвлөх ажлыг хангалтгүй хийж байна.**

2.1.1. Сумын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр иргэдээс гаргасан ТАХ-ний саналыг эрэмбэлэх, боловсруулах ажил хангалтгүй хийгдсэн байна. 13-14

2.1.2. Аймгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г ОНО-той төлөвлөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг нь чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. 14-15

**2.2. Сумдын ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахад холбогдох журмыг хэрэгжүүлээгүй байгаа нь ОН дахь боловсон хүчний мэдлэг чадвараас хамаарсан байна.**

2.2.1. Үнэлгээний хорооны гишүүдийн ур чадвар хангалтгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүн, чанарт сөргөөр нөлөөлсөн байна. 16-21

2.2.2. ОНХС-ийн хөрөнгийг сум орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн ТАХ-г санхүүжүүлэхэд бүрэн зарцуулаагүй байна. 21-31

2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 614,3 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй байна. 31-32

**БҮЛЭГ 3. ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан ч хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсан байна.**

### **3.1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийсэн хяналт үр дүнгүй байна.**

3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийх хяналтад иргэд, ИНБ-ын оролцоог ханаагүй байна. 32-33

3.1.2. ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний ажил хангалтгүй хийгдэж байгаагаас сангийн үйл ажиллагааны үр дүн сайжрахгүй байна. 34

### **3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг хугацаанд нь тайлагнаж, хүргүүлсэн байна.**

3.2.1. ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. 34

3.2.2. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 92,4 хувьтай байна. 35

3.2.3. Иргэдийн санал, оролцоонд үндэслэн ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөж байгаа үйл явц нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгыг бүрэн хангах нөхцлийг бүрдүүлээгүй байна. 35-37

|         |       |
|---------|-------|
| ДҮГНЭЛТ | 38-39 |
| ЗӨВЛӨМЖ | 40-41 |

Холбогдох байгууллагын санал.....

## Товчилсон үгийн тайлбар

|        |                                                 |
|--------|-------------------------------------------------|
| МУ     | Монгол улс                                      |
| ЗГ     | Засгийн газар                                   |
| ҮАГ    | Үндэсний аудитын газар                          |
| НАГ    | Нийцлийн аудитын газар                          |
| ТАГ    | Төрийн аудитын газар                            |
| ШӨХТГ  | Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар     |
| ИТХ    | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                    |
| ЗДТГ   | Засаг даргын тамгын газар                       |
| СХАА   | Санхүүгийн хяналт, аудитын алба                 |
| ГХБХБГ | Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар |
| ОНХНС  | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан               |
| ОНХС   | Орон нутгийн хөгжлийн сан                       |
| УТХО   | Улсын төсвийн хөрөнгө оруулалт                  |
| НАТ    | Нөөц ашигласны төлбөр                           |
| АМХТЗ  | Ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрөл        |
| АБХТЗ  | Ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл     |
| ХО     | Хөрөнгө оруулалт                                |
| ОНХО   | Орон нутгийн хөрөнгө оруулалт                   |
| ХАА    | Худалдан авах ажиллагаа                         |
| ТЭЗҮ   | Техник эдийн засгийн үндэслэл                   |
| УТ     | Улсын төсөв                                     |
| ТАХ    | Төсөл арга хэмжээ                               |
| АШБ    | Анхан шатны баримт                              |
| БИНХ   | Багийн иргэдийн нийтийн хурал                   |
| ОУБ    | Олон улсын байгууллага                          |

|               |                                                                                             |
|---------------|---------------------------------------------------------------------------------------------|
| АТГ           | Авлигатай тэмцэх газар                                                                      |
| ТЗБ           | Төрийн захиргааны байгууллага                                                               |
| ТӨБЗГ         | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар                                                   |
| МУЗЗНДНТУТХ   | Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль           |
| ТБОНӨХБАҮХАТХ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ОНӨХХК        | Орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани                                     |
| ХХК           | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                                                        |
| ТББ           | Тендерийн баримт бичиг                                                                      |
| ОНО           | Олон нийтийн оролцоотой                                                                     |
| НТШ           | Нээлттэй тендер шалгаруулалт                                                                |
| ХБТХ          | Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс                                                        |
| СТСХ          | Санхүү, төрийн сангийн хэлтэс                                                               |

**Хүснэгтийн товъёог:**

| №         | Тайлбар                                                           | Хуудасны дугаар |
|-----------|-------------------------------------------------------------------|-----------------|
| Хүснэгт 1 | Орлогын шилжүүлэг                                                 |                 |
| Хүснэгт 2 | ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл                       |                 |
| Хүснэгт 3 | Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн суурь тооцоолол |                 |
| Хүснэгт 4 | Өмнө оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт               |                 |

**Дүрслэлийн товъёог:**

| №         | Тайлбар                                                                  | Хуудасны дугаар |
|-----------|--------------------------------------------------------------------------|-----------------|
| Дүрслэл 1 | Гүйцэтгэгч компаниудын давхардсан хугацаанд гүйцэтгэсэн ТАХ-ний судалгаа |                 |

**Графикийн товъёог:**

| №        | Тайлбар                                                         | Хуудасны дугаар |
|----------|-----------------------------------------------------------------|-----------------|
| График 1 | Сумдад хэрэгжүүлсэн ТАХ-ны төрөл                                |                 |
| График 2 | Зохион байгуулсан ХАА-ны төрөл                                  |                 |
| График 3 | ОНХС-аас хэрэгжүүлсэн ТАХ-ны гэрээний үнийн дүн, эзлэх хувь     |                 |
| График 4 | Аймаг, сумдад хэрэгжүүлсэн ТАХ-ний тоо, санхүүжилтийн гүйцэтгэл |                 |

**Хавсралтын товъёог:**

| №          | Тайлбар                                                                            | Хуудасны дугаар |
|------------|------------------------------------------------------------------------------------|-----------------|
| Хавсралт 1 | Иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй, ИТХ-аар баталж, санхүүжүүлсэн ТАХ-ний жагсаалт  |                 |
| Хавсралт 2 | ИТХ-аар өөрчлөлт оруулж баталсан ТАХ-ний жагсаалт                                  |                 |
| Хавсралт 3 | Сумдын багийн ИНХ-ын оролцогчдын ирцийн судалгаа                                   |                 |
| Хавсралт 4 | ОНХС-аас ТЭЗҮ, зураг, төсөвгүй хийгдсэн ажлын судалгаа                             |                 |
| Хавсралт 5 | Орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаагүй ОНХС-аас санхүүжүүлсэн ТАХ-ны жагсаалт |                 |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрх, Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2019 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.

### Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх;

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, ЭЗТХ, багийн Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгалаа.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн аудит.Тулгуур зарчим MNS 6817:2020, Нийцлийн аудитын зарчим MNS 6817-6:2020, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, Сангийн яам, аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөөг тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- МУ-ын Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал
- Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244

**Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа**

дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”

- Сангийн сайдын 2018 оны 9 сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”

Бусад холбогдох хууль, дүрэм, журам.

Аудитын дэд хөтөлбөрийг 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдөр батлуулж, гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатны ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитор Л.Равдандорж нар хэрэгжүүлэн, аудитыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Ариунаа удирдаж, аудитын менежер Ч.Хэрлэнчимэг аудитын стандарт, арга зүйн дагуу үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн.


Аудитын тайлан, судалгааг 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор нэгтгэн, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар баталгаажуулж, Үндэсний аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

**БҮЛЭГ 1. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, орлого бүрдүүлэлтэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.**

**Ерөнхий мэдээлэл:**

ОНХНС-аас 2019 онд Дорноговь аймгийн ОНХС-д 5544,1 сая төгрөгийн санхүүжилт олгож, аймгийн хэмжээнд 5175,2 сая төгрөгийн, 128 шинэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

График-1



ОНХС-ийн хөрөнгөөр 2019 хэрэгжүүлсэн ТАХ-ний судалгаанаас харахад барилга байгууламж 5,5 хувь, тоног төхөөрөмж нийлүүлэх 18,8 хувь, их засварын ажил 15,6 хувь, явган хүний зам, тоглоомын талбай байгуулах, гудамжны гэрэлтүүлэг зэрэг тохижилтын ажил 34,4 хувь, дэд бүтэц 12,5 хувь, худаг ус гаргах, хөдөө аж ахуйн чиглэлд 13,3 хувийг тус тус эзэлж байна.

**1.1 ОНХНС-тай холбоотой Үндэсний аудитын газрын НАГ-ын аудитын багийн шалгах асуудал тул үзээгүй болно.**

**1.2. Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, бүрдүүлэлтэд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.**

**1.2.1. Аймгийн ОНХС-ийн гадаад, дотоодын хандив, тусламжийн эх үүсвэрийг боломжит хэмжээнд төлөвлөөгүй байна.**

60.2.Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

60.2.1. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг;

60.2.2. Энэ хуулийн 59.2-т заасан хөрөнгө;

60.2.4. Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр;

60.2.5. Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран

хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг.

60.2.6. Ашигт малтмалын тухай хуулийн 47<sup>3</sup> дугаар зүйлд зааснаас бусад ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувь;

60.2.7. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100 хувь, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь байхаар тусгасан.

МУ-ын 2019 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-аас Дорноговь аймгийн ОНХС-д 6795,8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилахаар баталсан байна. Батлагдсан орлогын шилжүүлгийг нэр төрлөөр нь авч үзвэл дараах байдалтай байна.

### Орлогын шилжүүлэг

| Хүснэгт №1 |                  |                  |
|------------|------------------|------------------|
| Д/д        | Утга             | Дүн<br>/сая.төг/ |
| 1          | Дотоодын НӨАТ    | 1264.9           |
| 2          | Газрын тосны НАТ | 495.7            |
| 3          | АМНАТ            | 2045.9           |
| 4          | АМХТЗ-ийн төлбөр | 2227,3           |
| 5          | Дэмжлэг          | 458,8            |
| 6          | Урамшуулал       | 303,2            |
| Нийт       |                  | 6795,8           |

Нийт орлогын шилжүүлгийн 39,1 хувь буюу 2660,8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 60,9 хувь буюу 4135,1 сая төгрөгийг сумдын ОНХС-д хуваарилахаар төлөвлөж батлагдсан байна.

МУ-ын Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1, 6.2 дахь заалтуудад аймаг, сумын Засаг дарга ОНХС-ийн эх үүсвэрийг 4 төрлөөр тооцож төлөвлөхөөр заасан байна.

Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн заавар"-ын 3.4-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2018.12.03-ны өдрийн 9/08 тоот "Дорноговь аймгийн төсөв батлах тухай" тогтоолоор ОНХС-ийн эх үүсвэрт хандив тусламжид 180,7 сая төгрөг, зарлагын хэмнэлт буюу өмнөх оны үлдэгдэл 51,7 сая төгрөг, аймгийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлага 753,3 сая төгрөг, нийт 985,7 сая төгрөгийг нэмэгдүүлэн төлөвлөж, нийт 7781,5 сая төгрөгөөр ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөсөн байна.

ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг аймгийн хэмжээнд журамд заасны дагуу нэр төрөл бүрээр төлөвлөсөн хэдий ч гадаад, дотоодын хандив тусламжийн орлогыг боломжит хэмжээгээр төлөвлөөгүй байна.

### **1.2.2. ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн бүрдүүлэхэд орон нутгаас мэдээлэл солилцож, оролцоог хангах асуудал орхигдсон байна.**

ОНХНС-аас нийт 6795,8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 5544,1 сая төгрөг байна.

Аймгийн ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг орлогын нэр төрлөөр харуулбал:

### ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

Хүснэгт №2

| №               | Эх үүсвэр                                    | Батлагдсан хуваарь | Нийт төвлөрсөн орлого | Олгосон санхүүжилт | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү         | Гүйцэтгэлийн хувь |
|-----------------|----------------------------------------------|--------------------|-----------------------|--------------------|--------------|--------------|---------------|-------------------|
| 1               | Дотоодын НӨАТ                                | 1264,9             | 1339,1                | 1339,1             |              |              | -74,2         | 105,9             |
| 2               | Газрын тосны НАТ                             | 495,7              | 318,1                 | 327,9              |              |              | 167,8         | 66,1              |
| 3               | АМНАТ                                        | 2045,9             | 2149,3                | 2139,5             |              |              | -93,6         | 104,6             |
| 4               | АМХТЗ-ийн төлбөр                             | 2227,4             | 975,6                 | 975,6              |              |              | 1251,8        | 43,8              |
| 5               | ОУ-ын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал     | 303,2              | 303,2                 | 303,1              |              |              | 0,1           | 100               |
| 6               | ОУ-ын төсөл хөтөлбөрөөс ОНХС-д олгох дэмжлэг | 458,8              | 458,8                 | 458,8              |              |              | 0             | 100               |
| <b>Нийт дүн</b> |                                              | <b>6795,9</b>      | <b>5544,1</b>         | <b>5544,1</b>      |              |              | <b>1251,8</b> | <b>81,6</b>       |
| 7               | Хандив тусламжид                             |                    |                       |                    | 180,7        | 160,6        | 20,1          | 88,9              |
| 8               | Зарлагын хэмнэлт буюу өмнөх оны үлдэгдэл     |                    |                       |                    | 51,7         | 51,9         | -0,2          | 100,4             |
| 9               | Аймгийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлага |                    |                       |                    | 753,3        | 753,3        | 0             | 100               |
| <b>Нийт дүн</b> |                                              |                    |                       |                    | <b>985,7</b> | <b>965,8</b> | <b>19,9</b>   | <b>98,0</b>       |

ОНХС-ийн эх үүсвэрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг авч үзэхэд:

- Газрын тосны НАТ 33,9 хувь, АМХТЗ-ийн төлбөр 56,2 хувиар биелэгдээгүйгээс аймгийн ОНХС-д 1251,8 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС-аас дутуу олгосон байна.

Сангийн сайдын 2016 оны 17 тоот тушаалын I хавсралтаар батлагдсан "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогоос орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 3.5-д "Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.6, 60.2.7 дахь хэсэгт заасан орлогын төсөөлөл болон улирлын гүйцэтгэлийн мэдээг Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар нь аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ" гэж заасан байна.

Гэтэл орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтнууд АМНАТ, АБХТЗ-ийн орлогын гүйцэтгэлийн мэдээг холбогдох газруудаас авч, тухай бүр хяналт тавьж, тооцоо хийгээгүй, орлогыг бүрдүүлэх тал дээр хамтарч ажиллаагүйгээс тус орлогын төлөвлөгөө тасарч, ОНХС-ийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

- Орон нутгийн хөгжлийг дэмжих хандив тусламжийн орлогын төлөвлөгөө 11,1 хувиар тасарсан байна. Аймгийн Засаг дарга тухайн орон нутагт үйл ажиллагааг явуулж байгаа Доншень-Монгол газрын тос, Смарт ойл, Зон хэ юу тан ХХК-иудтай байгуулсан нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд жил бүр 180,7 сая төгрөгийн хандив тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэхээр төлөвлөсөн байх боловч гүйцэтгэлийг үзэхэд 2018, 2019 онуудад Доншень-Монгол газрын тос ХХК нь тухайн үйл ажиллагаа явуулж байгаа суманд ХО-ын ажил хийсэн гэх шалтгаанаар, мөн Зон Хэн Юу Тиан Лимитед ХХК нь хандивын мөнгийг холбогдох дансанд төвлөрүүлээгүй байна.

Мөн Айраг, Хатанбулаг, Хөвсгөл сумдын ЗДТГ-т дотоодын аж ахуйн нэгжүүдээс 148,5 сая төгрөгийн хандив, тусламж олгосныг ОНХС-д төвлөрүүлээгүй, байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байгаа нь МУ-ын Төсвийн тухай хуулийн 60.2.5-д "ОНХС нь тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоод, гадаадын хандив, тусламж, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байгаа олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэгээс бүрдэнэ" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8.8-д тус сангийн тухайн төсвийн жилд зарцуулаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган, ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ гэж заасан. Гэтэл аймаг, сумдын ОНХС-ийн 2018 оны зарцуулагдаагүй үлдэгдэл 190,7 сая төгрөгийг дараа оны төсвийн эх үүсвэрт оруулж батлуулаагүй, 2019 оны зардлын хэмнэлт 343,2 сая төгрөгийг ирэх оны төсөвт тусгаж батлуулахгүйгээр тайлант хугацааны эцэст ИТХ-аар тодотгож, ТАХ-г санхүүжүүлсэн байна.

### **1.2.3. Аймгийн ОНХС-аас сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу хуваарилсан байна.**

Төсвийн тухай хуулийн 59.3-т "ОНХС-аас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлох итгэлцүүрээр тогтооно", мөн Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолын I хавсралтаар батлагдсан "ОНХНС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын дагуу сумдын хөгжлийн индекс, хүн амын тоо, нутаг дэвсгэрийн алслалт, орон нутгийн татварын идэвх санаачилга зэрэг үзүүлэлтүүдийг харгалзаж сумдад олгох орлогын шилжүүлгийг дараах байдлаар хуваарилсан байна.

### **Аймгийн ОНХС-аас сумдад олгох орлогын шилжүүлгийн суурь тооцоолол /сая.төг/**

Хүснэгт №3

| Д/д         | Сум           | Сумдын ОНХС-д итгэлцүүрээр хуваарилах суурь дүн |                           |                     |                 | Сумдад хуваарилагдах суурь тооцооллын нийт дүн |
|-------------|---------------|-------------------------------------------------|---------------------------|---------------------|-----------------|------------------------------------------------|
|             |               | Итгэлцүүрээр хуваарилах суурь дүн               | АМХБАТЗ-ийн төлбөрийн 50% | Дэмжлэг, урамшуулал | Бусад эх үүсвэр |                                                |
| 1           | Айраг         | 67,9                                            | 57,7                      | 50,4                | 0               | 176,1                                          |
| 2           | Алтанширээ    | 35,5                                            | 124,4                     | 26,3                | 3,9             | 190,0                                          |
| 3           | Даланжаргалан | 48,3                                            | 96,9                      | 36,2                | 23,1            | 204,6                                          |
| 4           | Дэлгэрэх      | 37,5                                            | 51,7                      | 15,8                | 0               | 105,1                                          |
| 5           | Иххэт         | 42,3                                            | 53,5                      | 31,6                | 0               | 127,4                                          |
| 6           | Мандах        | 60,3                                            | 422,1                     | 44,9                | 24,6            | 551,9                                          |
| 7           | Өргөн         | 44,4                                            | 133,1                     | 32,8                | 0               | 210,2                                          |
| 8           | Сайхандулаан  | 43,2                                            | 415,4                     | 31,9                | 0               | 490,5                                          |
| 9           | Улаанбадрах   | 52,3                                            | 296,5                     | 38,8                | 0               | 387,7                                          |
| 10          | Хатанбулаг    | 103,0                                           | 233,0                     | 76,2                | 0               | 412,2                                          |
| 11          | Хөвсгөл       | 46,5                                            | 87,9                      | 34,6                | 0               | 169,0                                          |
| 12          | Эрдэнэ        | 54,1                                            | 119,4                     | 40,3                | 0               | 213,8                                          |
| 13          | Сайншанд      | 164,7                                           | 135,8                     | 121,7               | 59,1            | 481,3                                          |
| 14          | Замын-Үүд     | 286,5                                           | 0                         | 180,4               | 0               | 466,9                                          |
|             | Дүн           | 1086,6                                          | 2227,4                    | 762,0               | 59,1            | 4186,7                                         |
| 15          | Аймгийн ОНХС  | 2535,4                                          | 0                         | 0                   | 1059,4          | 3594,8                                         |
| <b>Нийт</b> |               | <b>3622,0</b>                                   | <b>2227,4</b>             | <b>762,0</b>        | <b>1118,5</b>   | <b>7781,5</b>                                  |

Сангийн сайдын 2018 оны 228 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн заавар"-ын 3.3-т заасны дагуу аймгийн ИТХ-ын 2018.12.03-ны өдрийн 9/08 тогтоолоор ОНХС-аас аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг тогтоосон байна.

**БҮЛЭГ 2. ОНХС-ийн үйл ажиллагааны төлөвлөлт хангалтгүй хийгдэж байгаагаас сангийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй байна.**

**2.1. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх ТАХ-г олон нийтийн оролцоотой төлөвлөх ажлыг хангалтгүй хийж байна.**

Аймаг, сумдын БИНХ-аас ОНХС-ийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хийгдэх ТАХ-г төлөвлөх ажлын хүрээнд иргэдээс нийт 6799 саналын хуудсыг нэгтгэн эрэмбэлж, 926 саналыг БИНХ-ын тогтоолоор баталгаажуулан сумын ажлын хэсэгт хүргүүлж, аймаг, сумдын ИТХ-аар нийт 128 ТАХ-ээг хэрэгжүүлэхээр баталсан байна.

**2.1.1. Сумын түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр иргэдээс гаргасан ТАХ-ний саналыг эрэмбэлэх, боловсруулах ажил хангалтгүй хийгдсэн байна.**

Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 6.3 дахь заалтаар ОНХС-аар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг төлөвлөхөд баримтлах нөхцөлүүдийг тусгасан байх ба тус нөхцөлүүдийг баримтлаагүй дараах зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

- Журмын 6.3.1-т "Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан зүйлийг баримтлах буюу 60.3.6 орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг төлөвлөхгүй байх" гэсэн байна. Сумдын хэмжээнд ОНХС-аас 2019 онд нийт 120 ТАХ-г хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 43 ТАХ-г хэрэгжүүлсэн. /Хавсралт-1/
- Мөн Сангийн сайдын 2014 оны 43 тоот тушаалаар батлагдсан зааврын 3.3-т ОНХС-ийн хөрөнгийг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлж, жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор /өмнө оны/ батална гэж заасан байхад Айраг, Даланжаргалан, Сайншанд, Замын-Үүд, Хатанбулаг, Хөвсгөл, Эрдэнэ сумд тус заалтыг зөрчин ОНХС-аас 2019 онд хэрэгжүүлэхээр батлагдсан ТАХ-ний жагсаалтад өөрчлөлт оруулж, хэрэгжүүлсэн байна. /Хавсралт-2/
- Дээрх журмын 5.2-т багийн ИНХ-ын дарга ирэх онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ны жагсаалтыг хэлэлцэж санал хураах хурлыг жил бүрийн 5 дугаар сард багтаан зохион байгуулна гэж заасан байхад Айраг сумын 4, Иххэт сумын 1, Өргөн сумын 1, Хөвсгөл сумын 3, Эрдэнэ сумын 5 баг ИНХ-ыг дээрх хугацаанд зохион байгуулаагүй байна.
- Журмын 5.4-т багийн ИНХ-ыг МУЗЗНДНТУТХ-ийн 23.10-т "Баг, хорооны Хурлын хуралдаанд зөвхөн тухайн баг, хорооны сонгуулийн насны иргэн

бүр оролцож болох бөгөөд хуралдаанд багт 4 өрх тутмаас, хороо, аймгийн төвийн сумын багт 20-30 өрх тутмаас тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хүчинтэйд тооцно" гэж заасан байна.

Гэтэл аймгийн 14 сумын, 64 багийн, 20844 өрхөөс 3614 өрх БИНХ-д оролцохоор байгаагаас 4923 иргэн хамрагдсан боловч 11 сумын 35 багийн ИНХ-ын тэмдэглэлд багийн нийт иргэдийн хэдэн хувь, хэчнээн өрхийн төлөөлөл оролцсон нь тодорхойгүй, зөвхөн иргэдийн тоо, хүйсийг тэмдэглэсэн, мөн Иххэт сумын Бүрдэнэ баг, Эрдэнэ сумын Улаан-Уул багуудын ИНХ-ын ирц хангагдаагүй, Сайхандулаан сумын Улаан шороот, Цохио багуудын ИНХ-ын холбогдох баримт материал байхгүй, Эрдэнэ сумын Дөрвөлж багийн ирц байхгүй байна.

- Журмын 5.5-д багийн ИНХ-ын дарга хурлын ирцийг бүртгэн, оролцогчоор гарын үсэг зуруулж, хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг хөтөлж, тэмдгээр баталгаажуулна гэсэн байхад 7 сумын 15 багт ирцийг гарын үсгээр баталгаажуулаагүй байна. /Хавсралт-3/
- Журмын 5.6-д багийн Засаг дарга ИНХ-д өмнөх жилд ОНХС-аас хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, арга хэмжээний талаар тайлагнаж, хөндлөнгийн хянагч, үнэлэгч нарын тайланг сонсоно гэж заасан байхад бүх сумдын нийт багуудад ИНХ-д хөндлөнгийн хянагч, үнэлэгч нарын тайлан танилцуулагдаагүй, мөн 8 сумын 34 БИНХ-д өмнөх жилд хэрэгжүүлсэн ТАХ-ны талаар тайлагнаж хэвшээгүй байна.
- Журмын 5.7-д багийн Засаг дарга ИНХ-д иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харьяа сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ гэсэн байхад ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлтийн ажилд БИНХ-аас ирсэн саналыг нэгтгэж сумын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан эрэмбэлэх ажил сумдад хангалтгүй хийгдсэн байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд сумын түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх талаар багийн Засаг дарга нь сумын ЗДТГ-тай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, аймаг, сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой ХО, ТАХ-ний танилцуулгыг бэлтгэж, мэдээ мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд танилцуулахаар тусгасан байна.

Иргэдэд мэдээлэл хүргэх ажил орхигдсоноос орон нутгийн хөгжлийг дэмжсэн, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ТАХ-г саналдаа тусгаж чадахгүй байна.

**2.1.2. Аймгийн түвшинд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-г ОНО-той төлөвлөх, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг нь чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.**

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ийн 6-д Аймаг, нийслэлийн түвшинд ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөх талаар тусгасан байна.

- Журмын 6.2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны ОНХС-ийн хөрөнгөөр дараа жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр ТАХ-ний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого чиглэл, Засаг даргын мөрийн хөтөлбөрт туссан үйл ажиллагаа, урьд оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ээг харгалзан боловсруулна”, 6.3-т “Дээрх жагсаалтад сум, дүүргийн иргэдийн саналыг авсан аймаг, нийслэлийн чиг үүрэгт хамаарах саналын жагсаалтыг мөн оруулна” гэж заасан байдаг. Гэтэл аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх 47 ТАХ-ний урьдчилсан жагсаалтыг боловсруулсан боловч сумын иргэдээс аймгийн чиг үүрэгт хамаарах ТАХ-ний саналыг аваагүй байна.
- Журмын 6.5-д “Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэний танхимаар хэлэлцүүлсэн ТАХ-ний саналыг нэгтгэн, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 7-оос доошгүй хүнтэй ажлын хэсгийг ЗДТГ, ХБХ, СТС-ийн хэлтсийн холбогдох ажилтнууд болон иргэний нийгмийн төлөөлөл оролцуулан Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулан байгуулна” гэж заасан байхад аймгийн Засаг даргын 2018 оны А/759 дугаар захирамжаар баталсан ажлын хэсэг 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний саналыг нэгтгэх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах, эрэмбэлэх ажлыг хийгээгүй байна.

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд аймгийн түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөх талаар аймгийн Засаг дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө, оруулалт, ТАХ-г олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг томилох бөгөөд тус ажлын хэсэг нь урьдчилсан жагсаалтыг бэлтгэж багийн санал авах үйл ажиллагаатай хамтад нь зохион байгуулахаар тусгасан байна.

Гэтэл дээрх ажил хангалтгүй хийгдсэнээс аймгийн хөгжлийн бодлого чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, өмнөх онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ХО, ТАХ-ний талаар мэдээллийг олон нийтэд хүргэх ажил хангалтгүй байгаагаас иргэд хөгжилд чиглэсэн ТАХ-г хэрэгжүүлэх талаар саналдаа тусгаж чадахгүй байна.

Аудитын явцад ОНХС-ийн үйл ажиллагааны талаар авсан санал асуулгад аймгийн нийт хүн амын 0,5 хувь буюу 357 иргэн хамрагдсан байна. Нийт хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн байдлаар нь авч үзвэл төрийн албан хаагч 147, бизнес эрхлэгч 52, малчин 59, ажилгүй 29, тэтгэврийн насны 70 хүн хамрагдсан байна.


ОНХС-ийн талаар мэдээлэлтэй байдаг эсэх талаарх асуулгад 55,5 хувь нь хангалтгүй мэдээлэлтэй байдаг, 28,3 хувь нь ОНХС-ийн талаар огт мэдэхгүй, 55,2 хувь нь 2019 оны ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний талаар санал өгөөгүй, 58 хувь нь орон нутгаас таниулах сурталчлах ажил хийгээгүй талаар тусгасан байна.

Санал асуулгын нэгтгэлээс харахад оролцсон иргэдийн дийлэнх нь ОНХС-ийн үйл ажиллагааны талаар ойлголтгүй, мэдээлэл дутмаг, санал өгөх болон хэрэгжүүлсэн ТАХ-ны гүйцэтгэлд хяналт тавих үйл ажиллагаанд оролцдоггүй, орон нутагт хэрэгжүүлсэн ТАХ-ны гүйцэтгэлийн чанар байдалд сэтгэл хангалуун бус байдаг байна.

**2.2. Сумдын ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахад холбогдох журмыг хэрэгжүүлээгүй байгаа нь ОН дахь боловсон хүчний мэдлэг чадвараас хамаарсан байна.**

**2.2.1. Үнэлгээний хорооны гишүүдийн үр чадвар хангалтгүй байгаа нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүн, чанарт сөргөөр нөлөөлсөн байна.**

Дорноговь аймагт ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд шинээр 6725.4 сая төгрөгийн, нийт 128 ТАХ-г хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ХАА-г зохион байгуулсан байна. Үүний 18 ТАХ нь НТШ, 48 ТАХ-г харьцуулалтын, 13 олон нийтийн оролцоотой, 49 шууд гэрээг байгуулсан байна.



Аймгийн хэмжээнд зохион байгуулсан нийт ХАА-ны 33 ТАХ буюу 25,8 хувийг аймаг, Сайншанд, Замын-Үүд суманд, 95 ТАХ буюу 74,2 хувийг бусад сумдад зохион байгуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн ТАХ-ний ХАА-ны 27.3 хувь буюу 35 ТАХ-ний ХАА-г холбогдох хууль, журмын дагуу хэрэгжүүлээгүй, үүнээс 26 ТАХ-ны ТББ-ийг боловсруулахдаа гэрээний тусгай нөхцөлд тусгах шаардлагатай мэдээллүүдийг орхигдуулсан, зарим ажлын тендерийн урилгыг сонинд нийтлээгүй, тухайн ХАА-нд мөрдөгдөх жишиг баримтыг мөрдөөгүй, ОНХС-аар хийгдэх ТАХ-ний жагсаалтад тусгагдсан нэрийг өөрчилсөн зэрэг зөрчлүүдийг гаргасан байна. Үүнд:

МУ-ын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т "Тендерийн баримт бичигт тендер оролцогч зохих шаардлага хангасан тендер бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, тендер оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, хамгийн сайн үнэлэгдсэн тендерийг шалгаруулах шалгуур үзүүлэлт, аргачлал, захиалагчийн санал болгож байгаа гэрээний нөхцөлүүд, техникийн тодорхойлолт, зураг, тендерийн жишиг маягтууд, зөвлөх үйлчилгээний хувьд ажлын даалгаврыг тусгана" гэж заасан байхад ОНХС-ийн хөрөнгөөр ХАА-ний зохион байгуулах үнэлгээний хороо ТББ-г хангалтгүй боловсруулан байна.

- ✓ Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн Мандах наран-4 хорооллын гадна шугам сүлжээний ажлын ТББ-т гэрээний тусгай нөхцөлийг бүрэн боловсруулаагүй.
- ✓ Айраг сумын Ундны усны машин нийлүүлэх ажлын ХАА-г зохион байгуулахдаа үнэлгээний хороо нь техникийн тодорхойлолтод

- худалдан авах хөрөнгийн шинж чанар, техникийн үзүүлэлтийг тодорхой тусгаагүйгээс бүрэн ашиглах боломжгүй хөрөнгө бэлтгэсэн.
- ✓ Даланжаргалан сумын ЭМТ-ийн түргэн тусламжийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, ТББ-г боловсруулах, тендер хүлээн авах, нээх хугацаа зэрэг асуудлыг үнэлгээний хороогоор шийдвэрлэсэн тухай тэмдэглэл, дүгнэлт гаргаагүй.
  - ✓ Эрдэнэ сумын “Наадмын талбайн асар, үзэгчдийн суудал, саравч, бөхийн хөлийн асрын угсралт”-ын ажлын эхний сонгон шалгаруулалтаар Сизу ХХК, 2 дахь шалгаруулалтад Энх энэрлийн өргөө ХХК гомдол гаргасан байна. Үнэлгээний хорооны гишүүнийг нөхөн томилоогүй, гүйцэтгэгчийн ирүүлсэн ТББ-ийг буруу үнэлсэн зэрэг зөрчлөөс шалтгаалж тендер шалгаруулалт хойшлогдон ТАХ хэрэгжих хугацааны хязгаарлалтад оруулсан, мөн ТББ-т гэрээний тусгай нөхцөлийг боловсруулаагүй.
  - ✓ Мандах сумын Эрүүл мэндийн төвийн их засвар, хайс хашаа хийлгэх ажлын ТББ-ийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан нээлттэй тендер шалгаруулалтын тендерийн жишиг баримт бичгийн гэрээний тусгай нөхцөлийг боловсруулаагүй.
  - ✓ Мандах сумын Сумын ерөнхий төлөвлөгөө хийлгүүлэх ажлын тендерийн урилгыг сайтад байршуулахаар заасан хугацаанаас 3 хоногийн дараа байршуулсан.
  - ✓ Сайхандулаан сумын Хог зөөврийн машин /10 функер/ нийлүүлэх ажлын 2 дахь удаагийн ХАА-г зохион байгуулахдаа ажлын тоо хэмжээг багасгаж хогийн 6 функертэй машин нийлүүлэх ажил болгож зарласан.
  - ✓ Улаанбадрах сумын Хөдөөгийн багуудад 10 гүний худаг гаргах 149.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг харьцуулалтын аргаар зарласан.
  - ✓ Улаанбадрах сумын Төвийн бохир усны шугам сүлжээний ажлын ХАА-г НТШ-ын аргаар зарласан боловч харьцуулалтын аргын жишиг ТББ-ийг боловсруулсан.
  - ✓ Өргөн сумын “Найрамдал хорооны 6, 7 дугаар байрнуудын гадна фасад засварлах” ажлын ХАА-г зохион байгуулахдаа дээрх хуулийн 8.5 “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчиж, үргэлжлэн баригдсан нэг барилгад хийгдэх ижил төрлийн ажлыг 2 ХАА болгон харьцуулалтын аргаар зарлаж, гүйцэтгэгч 1 компанийг шалгаруулсан.
  - ✓ Хөвсгөл сумын “Төв талбай байгуулах” ажилд ХАА зарлаагүй.
  - ✓ Замын-Үүд сумын “Сумын нутаг дэвсгэрт шинээр хийгдэх гэрэлтүүлгийн ажил”-ын ТББ-ийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан тендерийн жишиг баримт бичиг мөрдөөгүй.
  - ✓ Замын-Үүд сумын “Гуравдугаар багт явган зам хийх” ажилд захиалагч талаас гүйцэтгэгчид тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэх шалгуур тавиагүй, ижил төрлийн ажил хийж байсан туршлагагүй иргэнтэй гэрээ байгуулж чанаргүй ажил гүйцэтгүүлсэн.
  - ✓ Замын-Үүд сумын “500 хүний суудалтай соёл спортын ордны гадна зам талбайн ажил”-ын ТББ-ийг боловсруулахдаа Сангийн сайдын 2012 оны 81 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт ажил гүйцэтгэх тендерийн жишиг баримт бичгийг мөрдөөгүй.

Захиалагч тендерт оролцогчдыг ил тод, нээлттэй, тэгш өрсөлдөх боломжоор хангахын тулд ТББ-ийг хуулийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, санхүү, техникийн чадавх, туршлагыг бодитоор үнэлэх боломжийг бүрдүүлж, худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримталж ажиллахаар хуульчилсныг зөрчин оролцогчдын тендерт оролцох боломжийг хязгаарласан дараах зөрчлүүдийг гаргасан байна.

- ✓ Алтанширээ, Даланжаргалан сумын “Төвлөрсөн шугам сүлжээний ажлын зураг төсөв хийлгэх” ажлыг ХАА зарлахгүйгээр 2018 онд Монкузбасс ХХК-аар гүйцэтгүүлэн зураг төсвийг боловсруулсан байх боловч 2019 онд сонгон шалгаруулалт зохион байгуулж, 3 оролцогчоос тухайн ажлыг гүйцэтгэсэн Монкузбасс ХХК-нийг гүйцэтгэгчээр шалгаруулсан.
- ✓ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 4.21-т “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно” гэж засан. Гэтэл Айраг сумын Шинэ суурьшилтын бүсэд цахилгааны шугам татах ажлын ХАА-г 39.7 сая төгрөгийн төсөвт өртгөөр 2 удаа зарлаж, шаардлагад нийцсэн тендерийн баримт бичиг ирүүлээгүй болон оролцогч байхгүй шалтгаанаар татгалзсан байх боловч төсөвт өртгийг 14.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, Содон эрчис ХХК-тай 53.9 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж, нэмэгдүүлсэн төсвийг сумын ИТХ-аар төсвийн тодотголоор нэмж баталсан.
- ✓ Иххэт сумын Дан болон давхар орон сууцны дунд тоглоомын талбай байгуулах ажилд 3 оролцогч материал ирүүлсэн байхад бага үнийн санал ирүүлсэн 2 оролцогчийн материалыг үнэлээгүй орхигдуулж, 1 оролцогчид давуу байдал үүсгэсэн.
- ✓ Сайхандулаан сумын 8 айлын орон сууц шинээр барих ажлын ХАА-г зохион байгуулахдаа ТББ-т тендерийн баталгаа байршуулах хугацааг 28 хоногоор заасныг 30 хоногоор баталгаа ирүүлсэн оролцогчийн материалаас татгалзаж шууд гэрээ байгуулсан. Мөн ТББ-ийн гэрээний тусгай нөхцөлд ажлыг өөрийн хөрөнгөөр 100% дуусгасны дараа санхүүжилтийг олгохоор хатуу нөхцөлийг тусгасан боловч ажил гүйцэтгэх гэрээнд урьдчилгаа 50 хувь, үлдэгдэл санхүүжилтийг гаргасан гүйцэтгэлээр олгохоор заасан.
- ✓ Иххэт сумын “Наадмын талбай шинээр барих” ажлын ТББ-т оролцогчийн санхүүгийн чадавхыг үнэлэхдээ 2017-2018 оны санхүүгийн аудитлагдсан тайланг ирүүлэхээр тусгасан боловч 2016 оны аудитлагдсан санхүүгийн тайлан болон Монгол банкны тодорхойлолт ирүүлээгүй гэсэн шалтгаанаар тендерийг хүчингүй болгосон, дахин НТШ зарлаж, шууд гэрээ байгуулах урилга хүргүүлсэн боловч амжилтгүй болсноос ТАХ хугацаандаа хэрэгжих боломжгүй болж, тухайн онд хэрэгжиж дуусаагүй.
- ✓ Сайхандулаан сумын ЕБС-ийн их засварын ажлын ТББ-т өөрийн хөрөнгөөр бүрэн дуусгасны дараа санхүүжилт олгохоор тусгасан боловч гэрээнд урьдчилгаа санхүүжилт олгохоор заасан.

- ✓ Хатанбулаг сумын “Спорт цогцолборт олгох дэмжлэг” ажил гүйцэтгэх сонгон шалгаруулалт явуулахгүйгээр шууд гэрээ байгуулж, 50,0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3.1.3-т "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ нь хуульд заасны дагуу зураг төсөв, ТЭЗҮ, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх" гэж заасан. Гэтэл 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжүүлэх 10 ТАХ зураггүй, тайлант хугацаанд 30 ТАХ-ний зураг боловсруулсан, төсөвгүй 7, тайлант хугацаанд төсөв боловсруулсан 39, ТЭЗҮ боловсруулаагүй 59 ажлуудыг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна. /Хавсралт-4/

Аудитад хамрагдсан хугацаанд тендерт шалгарсан зарим гүйцэтгэгч компаниуд давхардсан хугацаанд 2-5 ажлыг зэрэг гүйцэтгэснээс ажил гүйцэтгэх гэрээний хугацаа сунгагдаж, зарим ажлууд чанаргүй хийгдсэн байна.

Дүрслэл-1

| Мөнх хялмаа ХХК                                                                                                                                                                                                                                                                                                                                                                | Сизу ХХК                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Тольт дэнлүү ХХК                                                                                                                                                                                                                                           |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <ol style="list-style-type: none"> <li>1. Даланжрагалан сум ЭМТөвийн дээврийн засвар /2019,04,08-2019,04,25/</li> <li>2. Мандах сум Хуучин дотуур байрыг их засвар хийж төрийн албан хаагчийн орон сууц болгох /2019,06,10-2019,08,01/</li> <li>3. Замын-Үүд сум Мандах наран хороололос Заан зоог хүртэлх 800 метр урт явган зам хийх ажил /2019,05,01-2019,07,30/</li> </ol> | <ol style="list-style-type: none"> <li>1. Эрдэнэ сум Хүүхдийн цэцэрлэгийн гадна хашаа /2019,04,25-2019,06,07/</li> <li>2. Эрдэнэ сум Наадмын талбайн асар, үзэгчдийн суудал, саравч, бөхийн хөлийн асарын угсралт /2019,11,06-2019,12,16/</li> <li>3. Улаанбадрах сум Сумын төвийн бохир усны шугам сүлжээний ажил /2019,06,18-2019,10,02/</li> </ol> | <ol style="list-style-type: none"> <li>1. Мандах сум Сумын эрүүл мэндийн төвийн их засвар, хайс хашаа /2019,05,17-2019,08,30/</li> <li>2. Улаанбадрах сум Баянбогд багийн "Иргэдэд үйлчлэх төвийн барилга" шинээр барих /2019,04,26-2019,07,01/</li> </ol> |
| Эс жи эм ХХК                                                                                                                                                                                                                                                                                                                                                                   | Эхний эхэн ХХК                                                                                                                                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                            |
| <ol style="list-style-type: none"> <li>1. Дэлгэрэх сум Гудамжны гэрэлтүүлэг /2019,05,20-2019,06,20/</li> <li>2. Мандах сум Алхантаг багт иргэдэд үйлчлэх төв барих /2019,05,17-2019,08,01/</li> <li>3. Мандах сум Сумын соёлын төвийн халаалт, цахилгааны монтааж гэрэлтүүлэг шинэчлэх /2019,05,17-2019,08,01/</li> <li>4. Мандах сум Сумын төвийн гэр байрны</li> </ol>       | <ol style="list-style-type: none"> <li>1. Улаанбадрах сум Хөдөөгийн багуудад 10 гүний худаг шинээр гаргах /2019,05,08-2019,11,25/</li> <li>2. Хатанбулаг сум Отрын бүс нутагт гүний худаг гаргах /2019,05,16-2019,07,20/</li> </ol>                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                            |

ХАА-г зохион байгуулсан үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлд хурлаар хэлэлцэн шийдвэрлэгдсэн асуудалд гишүүдийн оролцсон байдал тодорхой бус, гаргасан шийдвэр, түүний үндэслэл, холбогдох мэдээллийг бүрэн тусгаагүй байна.

Сумдад ХАА-д оролцох эрхтэй ажилтан албан хаагч дутагдалтай байгаагаас зохион байгуулагдсан бүх ХАА-ны үнэлгээний хорооны бүрэлдэхүүн өөрчлөгдөөгүй, тус хорооны гишүүдийн мэдлэг чадвараас шалтгаалж техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээг боломжит хэмжээнд боловсруулаагүй, ТЭЗҮ, зураг, төсөвгүй ТАХ-ний ХАА-г зохион байгуулснаас ОНХС-ийн хөрөнгөөр чанаргүй ажлууд хийгдсэн байна.

МУ-ын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 43 дугаар зүйлийн 43.6-д “Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг уг хугацаа дуустал барьцаалах нөхцөлийг захиалагч тендерийн баримт бичигт тусгаж болно” гэж заасан. Уг нөхцөлийг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 5, Сайхандулаан сумын 1 ТАХ-г сонгон шалгаруулах ТББ-т тусгасан боловч мөрдөөгүйгээс 70,0 сая төгрөгийн чанарын баталгааны барьцаа хөрөнгийг холбогдох дансанд байршуулаагүй байна.

Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан “Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журам”-ын 2.2-т сумын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн аж ахуйн үйлчилгээ, нийтийн ариун цэвэр, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлэгээ, хог зайлуулалтыг хийх, сумын тохижилт ургамал цэцэгжүүлэлт, явган зам, хүүхдийн тоглоомын талбайг тохижуулах, арчлах ТАХ-г ОНО-той ХАА-г журмын дагуу зохион байгуулахаар заасан.

ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх 14 ТАХ-ний ХАА-г ОНО-оор 4 суманд гүйцэтгүүлэхээр зохион байгуулсан байна. Үүнээс 9 ТАХ-г ОНО-оор зарлах боломжгүй байсан бөгөөд ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад дараах зөрчил гаргасан байна. Үүнд:

- Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан ОНО-той ХАА-ны журмын 2.7-д Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааг зохион байгуулахад энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан жагсаалтад багтсан гурав болон түүнээс дээш бүлэгт үнийн санал авах урилгыг албан бичгээр, цахим шуудангаар хүргүүлэн, товлосон хугацаанд хүлээн авч, үнийн саналын нээлт хийж, харьцуулалтын аргаар шалгаруулахаар заасан байхад Даланжаргалан сумын “Далан түрүү рашааны эх хамгаалах” ажилд сонгон шалгаруулалт явуулаагүй, ИТХ-аас тухайн иргэдийн бүлгийг дэмжиж ажиллах хүсэлтэд үндэслэн шууд гэрээ байгуулсан.
- Хатанбулаг сумын “Гудамжны цамхагт гэрэл /6ш гэрэл/”-д ТББ-т тусгасан ажлын тоо хэмжээг бууруулж тендер зарласан боловч, төсөвт өртгийн хэмжээг бууруулаагүй ХАА-аг ХХК-ын дунд сонгон шалгаруулалтыг хийсэн.
- Хөвсгөл сумын “Чулуут багийн тохижилт”-д 2 дахь удаагийн тендерийн //урилгыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаагүй Улаанбаатар хотын харьяалалтай иргэдийн бүлэг сонгон шалгаруулсан байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7<sup>1</sup>.4 Олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагаанд тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан сонгон шалгаруулалт явуулах бөгөөд тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд орон нутгийн иргэдийг өргөнөөр оролцуулах зарчмыг баримтална гэсэн заалтыг мөрдөөгүй.
- Хөвсгөл сумын “Иргэдийн чөлөөт цагийн талбай байгуулах”-д олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд урилга нийтлээгүй.

Сангийн сайдын 2013 оны 39 дүгээр тушаалаар батлагдсан ОНО-той ХАА-ны журмын 1.2-т “Олон нийтийн оролцоотой бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад тус журмын 2 дугаар хавсралтаар баталсан жишиг баримт бичгийг хэрэглэнэ” гэж заасан байхад дараах сумдын ОНО худалдан авах ажиллагаанд ХХК-иуд тендерт оролцож шалгарсан байна.

- Хатанбулаг сумын “Хилийн заставын гэрэлтүүлэг”-ийн ажилд иргэдийн бүлгийн дунд сонгон шалгаруулалтыг явуулаагүй, ХХК-аар гүйцэтгүүлэхээр шалгаруулсан.
- Хатанбулаг сумын “Гудамжны камержуулалт”-д ХАА-ны урилга олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд нийтлээгүй, ХХК-аар гүйцэтгүүлэхээр шалгаруулсан.

Мөн тус журмын 2.4-т сумын ЗДТГ нь ОНО-той ХАА-д оролцох сонирхолтой бүлгээс ирүүлсэн хүсэлтэд үндэслэн иргэдийн бүлгийн жагсаалтыг бэлтгэх ба үндэслэлгүйгээр бүртгэхээс татгалзахыг хориглохоор тусгасан байхад сумдын ЗДТГ-ын холбогдох албан тушаалтнууд ОНО-той иргэдийн бүлгийг албан ёсоор бүртгээгүй байна.

### **2.2.2. ОНХС-ийн хөрөнгийг сум орон нутгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн ТАХ-г санхүүжүүлэхэд бүрэн зориулагдаагүй байна.**

Аймгийн хэмжээнд ОНХС-аас нийт 128 шинэ төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, 5175,2 сая төгрөгийг санхүүжүүлсэн байна.



МУ-ын Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйл, Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журамд төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г санхүүжүүлэх, мөн ОНХС-ийн үйл ажиллагааны журамд тус сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийн талаар тус тус заасан байдаг.

Төсвийн тухай хуулийн ОНХС-ийн хөрөнгөөс зарцуулахыг хориглосон дараах ТАХ-г санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Аймгийн хэмжээнд орон нутгийн иргэдийн саналыг аваагүй 43 ТАХ-г ИТХ-аар баталж, ОНХС-аас 897,2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4.3-т сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх ХО, хөтөлбөр, ТАХ-ний санал нь энэ журмын 3 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангаагүй бол нэгдсэн жагсаалтаас хасах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна. /Хавсралт-1/

- Орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй 13 ТАХ-г хэрэгжүүлэхэд ОНХС-аас 168,2 сая төгрөгийг олгосон байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 8.8-д "ОНХС-ийн тухайн төсвийн жилд зарцуулагдаагүй үлдэгдлийг дараагийн төсвийн жилийн ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрт тусган ИТХ-аар баталсны дагуу санхүүжүүлнэ" гэж заасныг зөрчсөн байна. /Хавсралт-5/
- Нийтийн эрх ашигт нийцээгүй, тус сангаас хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй дараах ажлуудыг ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна.
  - Хатанбулаг сумын Цагдаагийн барилгын их засварын 20,0 сая төгрөгийн ажлыг Баялаг иргэдийн бүлгээр гүйцэтгүүлсэн байна. ОНХС-ийн хөрөнгөөр 2 ажилчны гэрийн 212 м<sup>2</sup> ханын цаас наах, 87м<sup>2</sup> таазанд уналттай тааз, 4 ширхэг гэрлийн бүрхүүл, 40 ш нүдэн гэрэл, 4,7м<sup>2</sup> цонхны хуванцар тавиур, 2 дотор хаалга, 7,5м<sup>2</sup> плита, паркетан шал зэрэг ажлуудыг хийсэн.
  - Сайншанд сумын 8 дугаар багийн иргэдийн иргэний үнэмлэхийн хаягийг шинэчлэх үйлчилгээний хураамжид 2,8 сая төгрөгийг зарцуулсан.
  - Сайншанд сумын ОНХС-аас Сайншанд-Хот тохижилтын газарт 9,9 сая төгрөгийн автомашины мотор худалдан авч өгсөн.
- Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа дууссанаас хойш хугацаанд гүйцэтгэгч компаниас барилга, байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлтийг албан тоотоор ирүүлсэн байхад захиалагч гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавиагүй байна.
  - Хөвсгөл сумын ЭМТ-д 8,9 сая төгрөгийн үнэтэй цогцос хадгалах хөргөгч худалдан авах 01/2019 дугаартай гэрээг 2019.03.01-ний өдөр Мед буян ХХК-тай 2019.03.01-04.15-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр байгуулсан байна. Гэрээний 8.2-т "Гэрээг сунгах, өөрчлөх, цуцлах саналыг нөгөө талдаа 3 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ" гэж заасан байхад гүйцэтгэгч компаниас гэрээг сунгуулах талаар хүсэлт ирүүлээгүй, мөн тоног төхөөрөмжийг 2019.07.03-ны 01/2019 актаар хүлээн авч, гэрээний хугацааг 72 хоног хэтрүүлсэн байх боловч гэрээнд алданги тооцох талаар тодорхой заалт оруулаагүй байна.
  - Хөвсгөл суманд Иргэдийн чөлөөт цагийн талбайн ажлыг гүйцэтгүүлэхээр Т.Төмөрхүрд ахлагчтай Хөгжил бүлэгтэй 2019.07.22-ны өдөр 02 дугаартай, 15,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2019.07.22-2019.09.22-ны хугацаанд гүйцэтгэх гэрээг байгуулсан байна. Гэрээний 6.2-т "2 тал гэрээнд заасан хугацаанд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,3 хувийн торгууль төлнө" гэж заасан боловч 2019.10.14-ний өдөр ажил хүлээлцсэн акт үйлдэж, гэрээнд заасан хугацаанаас 23 хоногийн дараа хүлээн авсан байна.  
Мөн ажил гүйцэтгэх гэрээний 8.2-т "Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэнэ" гэж заасан байхад тус ажлыг гүйцэтгэгч Хөгжил иргэдийн бүлгээс 2019.07.22-ны өдөр цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж ажил хойшлогдсон шалтгаанаар гэрээг сунгуулах хүсэлт ирүүлсэн байх боловч ажил гүйцэтгэх гэрээний хугацаанд өөрчлөлт оруулаагүй байна.
  - Замын Үүд сумын 3 дугаар багт 200 метр явган хүний зам барих, 10,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг иргэн О.Цэцэгсүрэнгээр гүйцэтгүүлэх гэрээг

2019.10.30-ны өдөр байгуулж, ажлыг 2019.11.30-ны өдөр дуусгаж хүлээлгэн өгсөн байна.

- Замын-Үүд сумын 1 дүгээр багийн нийтийн орон сууцны гадна тохижилтын 10,0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхээр иргэн Б.Бат-Эрдэнээр 2019.04.01-2019.05.01-ний хугацаад гэрээ байгуулж гүйцэтгүүлэхдээ гүйцэтгэгч компаниас гэрээр сунгах талаар албан тоотоор хүсэлт ирүүлээгүй, тус бичгийн дагуу гэрээний хугацаанд өөрчлөлт оруулахгүйгээр 2019.06.03-нд хүлээж авсан байна.
- Даланжаргалан сумын Олон овоо багт гүний худаг шинээр гаргах 34,4 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Ус орги ХХК-аар гүйцэтгүүлэх гэрээг байгуулж, ажлыг 2019.04.19-2019.05.10-ны хугацаанд гүйцэтгэхээр гэрээнд тусгасан байна. Гэрээний тусгай нөхцөлийн 5-д “Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувиас тус тус хэтрэхгүй байна” гэж заасан байхад гүйцэтгэгч компани 2019.06.13-ны А/49 тоот албан бичгээр ажил хүлээлцэх тухай хүсэлт ирүүлж ажлыг хүлээлгэн өгсөн байна.

➤ МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээ хийхийг хориглосон байхад хүчин төгөлдөр бус АШБ-ыг үндэслэн ТАХ-ний санхүүжилт олгосон байна.

- Хөвсгөл сумын Элст багийн тохижилтыг гүйцэтгүүлэх 5,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхээр 2019.12.25-ны өдөр Эгшиглэн энтертайнмент ХХК-тай байгуулсан гэрээг гүйцэтгэгч компани тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр бус баримтаар 2019.12.30-ны өдөр ажлыг хүлээж авсан актад хэчнээн ширхэг тоног төхөөрөмж хүлээн авсан нь тодорхойгүй, гэрээ байгуулахад мөн тусгаагүй байна.
- Улаанбадрах сумын төвийн гэрэлтүүлгийн шинэчлэл, засварын 59,3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын захиалагчийн хяналтыг иргэн Б.Болдбаатараар гүйцэтгүүлэхээр 1,0 сая төгрөгийн гэрээг 2019.05.15-ны өдөр байгуулсан байх боловч тус гэрээнд гүйцэтгэгч гарын үсэг зурж баталгаажуулаагүй, гэрээнд гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хяналтыг хэрхэн хийх талаар зүйл заалт тусгагдаагүй, ажлын гүйцэтгэлд хяналт хийсэн дүгнэлтэд тухайн ажлын үр дүнгийн талаар дурдаагүй хүлээн авсан байхад 2019.12.25-ны 08 тоот төлбөрийн хүсэлтээр төлбөрийг шилжүүлсэн байна.
- Хатанбулаг сумын Отрын бүс нутагт гүний худаг гаргах 45,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Эхний эхэн ХХК-аар гүйцэтгүүлсэн байна. Эргэл багийн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт инженерийн хийцтэй худгийн цооног гаргах 15,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг гүйцэтгэхдээ хуучин байсан цооногийг сэргээн засварласан байх ба гүйцэтгэлд худгийн байшин барих, цахилгаан үүсгүүр тавих ажилд 3,0 сая төгрөг зарцуулснаар тусгаж, гүйцэтгэгч компанид санхүүжилтийг бүрэн олгосон байна. Гэтэл Хатанбулаг сумын иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу аудитын явцад тодруулахад иргэн Бямбажав 2,3 сая төгрөгийг өөрийн хөрөнгөөс гаргаж 2020 оны 9 дүгээр сард цооног дээр байшин барьсан байна.

➤ Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журмын 5.2-т “Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга

байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана” гэж заасан.

Нийт сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-г хүлээн авах ажлын хэсгийг сумын ЗД-ын захирамжаар томилж, тус ажлыг хүлээн авсан байгаа боловч ажлын хэсэгт томилогдсон гишүүдийн мэдлэг, чадвараас шалтгаалан чанаргүй ажлуудыг хүлээн авсан нийтлэг зөрчил байна.

- Хөвсгөл сумын Наадмын төв талбайд засвар хийх 5,0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Д.Ууганбаяр ахлагчтай Цахиур иргэдийн бүлгээр хийлгэхээр гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн байна. Гэрээний 3.3-т “Захиалагч нь засварын ажлын явцад хяналт тавих, хэрэв хүлээн авсан ажилд ямар нэг согог доголдол илэрвэл ажил хүлээн авснаас хойш 3 сарын дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй” гэж заасан байна. Гэтэл 2019.07.22-ны өдөр 5 хүний ажлын хэсгийн бүрэлдэхүүн акт үйлдэж тус ажлыг хүлээн авч ашиглалтад авсан байх боловч аудитаар газар дээр нь очиж танилцахад ажил чанаргүй хийгдсэн.



- Даланжаргалан сумын ЭМТ-ийн барилгын дээврийн засварын 18,6 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Мөнх хялмаа ХХК-аар гүйцэтгүүлж, 2019.04.30-ны өдөр хүлээж авсан байна. Аудитаар ажлын гүйцэтгэлийг үзэхэд хар цааснуудын амыг дараагүйгээс хуурч унасан, ажил чанаргүй хийгдсэн байна.



- Эрдэнэ сумын Наадмын хүндэт зочид, үзэгчдийн асар, гадна төмөр торон хашаа хийх 118,6 сая төгрөгийн төсөвтэй ажлыг СИЗУ ХХК-аар 2019.11.06-2019.12.16-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээнд асрын урд, хойд болон хажуу ханыг тоосгоор өнгөлж өрөх, дээврийн 15 мм зузаан цементэн тэгшилгээ хийх, дээврийн бетон тэгшилгээг 20 мм-ийн зузаантай хийх, шалыг тосон өнгийн будгаар гар аргаар сайн чанартай будах, сандлын

төмөр хийцийг төмрийн будгаар 2 удаа будах, модон тавцанг өнгийн тосон будгаар гар аргаар чанартай сайн будах, модон хийцүүдэд галаас хамгаалах бодис түрхэх зэрэг ажлууд тусгагдсан байх боловч ажлын гүйцэтгэлээс харахад дээрх ажлууд бүрэн хийгдээгүй байна.



- Хатанбулаг сумын Сургууль, цэцэрлэгийн худагт цэвэршүүлэх төхөөрөмж суурилуулах 15,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Ирмүүн бармат ХХК-аар гүйцэтгүүлж, 2019.05.03-ны өдөр №2019/01 тоот ажил хүлээлцэх актаар хүлээж авсан байна. Аудитаар ажлын гүйцэтгэлийг үзэхэд тус төхөөрөмж нь хүчдэл хүрэхгүйгээс шалтгаалан ашиглалтгүй байна.



- Хатанбулаг сумын Гудамжны камержуулалтын 20,0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг Компьютер плаза ХХК-аар 2019.06.07-2019.07.08-ны хугацаанд гүйцэтгүүлж, 2019.06.21-ний өдөр хүлээж авсан байх боловч төв серверийн камераас бусад камерууд ажиллахгүй, ашиглалтгүй байна.
- Айраг суманд Камержуулах тоног төхөөрөмж угсрах 9,9 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Милкилайн ХХК-иар гүйцэтгүүлж, 2019.05.20-ны өдөр актаар хүлээж авсан байх боловч өнөөдрийн байдлаар суурилуулсан 15 камер ашиглалтгүй байна.

Дээрх зөрчилд баталгаат хугацаанд дахин засварлуулах, бүрэн ашиглалтад хүлээн авахуулах тухай албан шаардлагыг хүргүүлэхээр шийдвэрлэв.

➤ ТБОНӨХБАҮХАТ хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй ХО-ын ТАХ-г төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно гэж заасан байхад Хөвсгөл сумын Ахмадын соёл үйлчилгээний төв байгуулах ажлын нийт төсөвт өртгийг хувааж 2 удаагийн тендер шалгаруулалт зохион байгуулсан байна. Дээрх асуудлаар АТГ-т шалгагдаж байгаа тул баримт материалыг үзэх боломжгүй байлаа.

➤ Алтанширээ сумын Гудамж талбай цэгцлэх 5,4 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Олон ширээ хоршоо 2019.04.30-2019.06.15-ны хооронд гүйцэтгэхээр гэрээ байгуулсан боловч ажиллах хүч олдоогүй гэсэн шалтгаанаар гэрээний хугацааг 3 удаа сунгуулсан байгаа нь захиалагч тал чадамжгүй гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан,

мөн компаниас ирүүлсэн хүсэлтийн шалтгаан нөхцөлийг үнэлэхгүйгээр шийдвэрлэж, сунгалт хийсэн байна.

➤ ХАА-г зохион байгуулсан үнэлгээний хорооны гишүүдийн мэдлэг чадвараас шалтгаалж техникийн тодорхойлолтыг боломжит хэмжээнд боловсруулаагүй, ОНХС-аас хэрэгжүүлэх ТАХ-ний эдийн засгийн үндэслэл, үр ашгийн тооцоо, хэрэгцээ, шаардлага, судалгаа, тооцоо, батлагдсан зураг төсвийг үндэслэн төлөвлөхөөр хуульчилсан ч дараах ажлуудын ТЭЗҮ хийгдээгүйгээс бүрэн ашиглах боломжгүй үр ашиг муутай ТАХ-ээг хэрэгжүүлсэн байна.

- Хөвсгөл суманд Ногоон байгууламж байгуулах 6,0 сая төгрөгийн ажлыг 2019.05.15-2019.10.15-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр ажил гүйцэтгэх гэрээг Ногоон төгөл бүлэгтэй байгуулсан байна. Тус ажлын техникийн тодорхойлолтод суулгацын нүх 70-75 см диаметртэй, суулгац хамгаалах хашаа нь 80-90 см диаметртэй дугуй хэлбэрийн байхаар тусгасан нь суулгацыг хашиж хамгаалах нөхцөлийг бүрдүүлээгүй байна.



- Айраг сумын Шинэ суурьшилтын бүсэд цахилгаан шугам татах 53,9 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Содон эрчис ХХК-иар гүйцэтгүүлж 2020.01.07-ны өдөр барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтээр хүлээн авсан байна. Тус ажлын техникийн тодорхойлолтод 10кв-ын дэд станц байгуулахаар тусгаж, гүйцэтгэгч ажлын даалгаврын дагуу гүйцэтгэн хүлээлгэж өгсөн боловч хүчдэлийн хэмжээ өндрөөс шалтгаалан өрхийн хэрэгцээнд шууд ашиглах боломжгүй, 2020 оны ОНХС-аас хүчдэлийг бууруулахад 40,0 сая төгрөгийг зарцуулахаар тусгасан байна.
- Хөвсгөл суманд төв талбай байгуулах 26,0 сая төгрөгийн, Иргэдийн чөлөөт цагийн талбай байгуулах 15,0 сая төгрөгийн өртөгтэй ажлууд хийгдсэн байна. Ажлын гүйцэтгэлийг авч үзэхэд иргэдийн чөлөөт цагийн талбайд 2,8 метрийн өндөртэй, 1 метрийн өргөнтэй, 3 тулгуур баганыг плитагаар битүү өнгөлсөн, хоорондоо төмөр холбоосоор холбогдсон, 6-7 метрийн диаметртэй, 20 см-ийн зузаантай бетонон суурь бүхий, өргөн 45 см, өндөр нь 90см металл хавтан дээр 1, 5, 9 дүгээр ноён хутагтуудын намтрыг бичиж байрлуулсан, энэ ажлын зардал нь 10,0 сая төгрөг байх бөгөөд нийт 5,0 сая төгрөгийн 2 ширхэг модон саравч хийгдсэн байна. Харин төв талбай байгуулах 26,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг гүйцэтгүүлэхээр 2019.05.28-ны өдөр Голомт пэйнт ХХК-тай 02 дугаарын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Тус ажлын техникийн тодорхойлолтод заагдсан ажлын гүйцэтгэлийг үзэхэд Д.Равжаагийн 5 метрийн өндөртэй хөшөө, 2 ш модон сүүдрэвч, 80 см-ийн өндөртэй төмөр шонтой 114 метр гинжээр холбосон хашлага, 4 ш гэрэлтүүлэг, амралтын сандал 20 ш, дөрвөн талаас 1,2 м-ийн өргөнтэй 315 м өнгөт хавтангаар явган хүний зам бүхий талбай байгуулсан байгаа нь ТЭЗҮ, ач холбогдлыг

үнэлээгүйгээс ашиглалтгүй, ижил төрлийн, үр дүнгүй ажлуудыг хийсэн байна.



- Улаанбадрах сумын төвийн бохир усны шугам сүлжээний угсралтын 120,9 сая төгрөгийн төсөвтэй ажлыг СИЗУ ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2019.07.23-ны өдөр гэрээ байгуулж, 2019.10.08-ны өдөр ажлыг хүлээн авч акт үйлдсэн байна. Тус суманд ОНХО-аар хийгдсэн цэвэр усны шугам сүлжээний ажил өнөөг хүртэл дуусаагүйтэй холбоотой дээрх шугам сүлжээний ажил ашиглалтгүй байна.
- Хатанбулаг сумын Өмчлөлийн газарт цахилгаан дамжуулах агаарын шугам татах 80,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг ДГС ХХК-аар гүйцэтгүүлж, сумын 5 дугаар багт шугамын ажлыг гүйцэтгэсэн байх боловч тус өмчлөлийн газарт айлууд суурьшаагүйгээс ашиглалтгүй байна.
- Алтанширээ суманд Бохирын машин худалдаж авах 36,7 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Тодбаярт ХХК-аар гүйцэтгүүлж, 2019.06.10-ны өдөр актаар хүлээж авсан байна. УТХО-ын 2019 оны хөрөнгөөр тус сум төвийн шугам сүлжээнд холбогдох ажлыг эхлүүлж, 2020 онд ашиглалтад орсноор бохирын машиныг ашиглах шаардлагагүй болсон.
- Алтанширээ суманд универсал трактор шинээр худалдан авах 69,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Петротрак ХХК нийлүүлж, 2019.07.05-ны өдөр хүлээлгэн өгсөн байна. Тракторын ашиглалттай танилцахад тус хөрөнгийг худалдан авснаас хойш хэрхэн ашигласан талаар бүртгэл судалгаа байхгүй байна.
- Алтанширээ сумын Гудамж талбай цэгцлэх 5,4 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Олон ширээ хоршоо гүйцэтгэж, 150 метр урттай, 1,4 метр өндөртэй хашааг гэр байрны хамгийн арын гудамжны эгнээний 5 айлын хашаатай давхардуулан барьсан байгаа нь сумын өнгө үзэмжийг сайжруулсан, үр дүнтэй ажил болж чадаагүй байна.



- Дэлгэрэх суманд Автомат худгийн иж бүрэн тоног төхөөрөмж, ус түгээх байрны хамт нийлүүлэх, суурилуулах 20,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Баялаг говь ХХК-аар гүйцэтгүүлж, 2019.06.20-ны өдөр актаар хүлээж авсан байх боловч иргэдэд ойртуулах үүднээс сонгосон байршил дахь усны чанараас шалтгаалан худаг ашиглалтгүй байна.
- Дэлгэрэх суманд Фитнесс төхөөрөмж худалдан авах 21,5 сая төгрөгийн ажлын гэрээг Бага хайрхан ХХК-тай байгуулж, тоног төхөөрөмжийг 2019.05.27-ны өдөр хүлээлцсэн байх боловч тус тоног төхөөрөмжийг байрлуулах газаргүй гэсэн шалтгаанаар өнөөдрийг хүртэл ашиглалтгүй, байна.
- Айраг суманд Усны автомашин нийлүүлэх 42,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Альянс трейд ХХК-аар гүйцэтгүүлж, 2019.04.29-ний өдөр хүлээн авсан байна. Тус ажлын техникийн тодорхойлолтод худалдан авах барааны шинж чанар, үзүүлэлтийг тодорхой тусгаагүйгээс хүйтний улиралд ашиглах боломжгүй машин худалдан авсан байна.

➤ Аудитад хамрагдсан 6954.3 сая төгрөгийн гэрээний үнийн дүнтэй, 42 ТАХ-ний гүйцэтгэлийг авч үзэхэд дараах ажлуудын санхүүжилтийг бодит гүйцэтгэлийг хянахгүйгээр санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

- Хөвсгөл сумын Чулуут багт Иргэдэд үйлчлэх төв бариулах 18,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2019.12.03-2019.12.28-ны хугацаанд Сэндвич угсралт иргэдийн бүлгээр гүйцэтгүүлэхээр оны эцэст буюу 2019.12.03-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Гэрээний 3.9-д “Гэрээнд заагдсан ажлыг зураг төсөл, стандартын дагуу чанартай гүйцэтгэн, энэхүү гэрээнд заасан хугацаа, хөрөнгийн хэмжээнд багтаан ашиглалтад оруулан, захиалагчид хүлээлгэн өгнө”, 11-т “Гэрээний төлбөрийг хийхдээ урьдчилгаа 12,6 сая төгрөгийг, ажил дуусаж хүлээн авах комисс акт үйлдсэний дараа 5,4 сая төгрөгийг төлнө” гэж заасан байна. Гэтэл 2019.12.24-ний өдөр ажил хүлээн авсан тэмдэглэлд ажлууд дутуу хийгдсэн шалтгаанаар 2020.03.30-ны өдөр дуусгах үүрэг өгсөн байх боловч ажил гүйцэтгэх гэрээг сунгаагүй, ажил бүрэн дуусаагүй байхад санхүүжилтийг 100 хувь олгосон байна.
- Хөвсгөл сумын ЕБС-д “Ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламж” төслийг ОНХС-аас 30,0 сая төгрөг, Дэлхийн зөн ОУБ, Мобиком корпорациас 40,0 сая төгрөгийг санхүүжүүлэх, нээлттэй тендер шалгаруулалтад Заг инженеринг ХХК шалгарсан байна. Тус төслийг хэрэгжүүлэхэд сумын ЗД-ын 2019.10.02-ны өдрийн А/107 тоот захирамжаар ЕБС-д хийгдэх ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн барилгын өргөтгөлийн ажлыг гүйцэтгүүлэхээр заг инженеринг ХХК-тай гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж, 30,0 сая төгрөгийн санхүүжилтийг ОНХС-аас олгохоор

захирамжилсан, мөн Дэлхийн зөн ОУБ-аас ирүүлсэн 2019.09.25-ны өдрийн 232/19 тоот албан бичгээрх хүсэлтийн дагуу 2019.10.25-ны өдөр 30,0 сая төгрөгийг гүйцэтгэгчийн дансанд шилжүүлсэн байна. Тус суманд 2020 онд төвлөрсөн халаалтын шугам сүлжээнд холбогдохоос шалтгаалан зураг, төсөв өөрчлөгдөж гэрээг цуцалсан, тус ажил өнөөдрийг хүртэл дуусаагүй.

- Хөвсгөл сумын ЕБС-ийн Соёлын танхимын засварын 27,0 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2018 онд Голомт пэйнт ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 13,5 сая төгрөгийн санхүүжилт олгосон байх боловч гэрээний хугацаанд ажлыг бүрэн дуусгаагүй, 2019 онд ОНХС-аас 8,1 сая төгрөгийн санхүүжилт олгосон байх боловч ажил өнөөдрийг хүртэл хийгдэж дуусаагүй.
- Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн шалыг шинэчлэх 26,9 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2019.07.04-2019.09.15-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр Харвайн толгой ХХК-тай гэрээ байгуулж, ажлыг 2019.09.15-ны өдөр хүлээн авч акт үйлдсэн байна. Ажил хүлээлцэх комисс 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байх ба актад шалны гадаргуу барзгар, хотгор гүдгэр, чулуутай байгаагаас хулдаас цоорсон, эмнэлгийн зориулалттай хулдаасаар солих шаардлагатай, төслийн хэрэгжилт 70 хувь хэрэгжсэн тул гишүүдийн 80 хувийн саналаар хүлээж авсан.
- Хатанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн цахилгааны монтажийг шинэчлэх 22,5 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Анар зоне ХХК-аар гүйцэтгүүлж, 2019.08.15-ны өдөр ажил хүлээлцсэн комиссын актад ил монтажийг үзэмжийн хувьд муу хийсэн талаар дурдаж ажлыг хүлээн авсан байна.
- Замын-Үүд сумын 1 дүгээр багийн 6 дугаар хэсэгт цэвэр, бохир усны шугамын өргөтгөл, гадна шугам өргөтгөн тавих ажлуудын ОНХС-А/06/2019, ОНХС-А/09/2019 дугаартай гэрээнүүдийг 2019.12.13, 23-ны өдрүүдэд Чандмань бадрал ОНӨХХК-аар гүйцэтгүүлэхээр байгуулж, тус хэсгийн айл өрхүүдийн гадна шугам өргөтгөн тавихад 4,9 сая төгрөг, цэвэр бохир шугамын 8,5 сая төгрөгийн нэг байршилд хийгдсэн ажлын бодит гүйцэтгэлийг хянахгүйгээр санхүүжилтийг бүрэн олгосон.
- Замын-Үүд сумын Соёл, спортын ордны гадна зам талбай хийх 171,8 сая төгрөгийн төсөвтэй ажлыг Борхойн зам ХХК-иар гүйцэтгүүлсэн байна. Тус барилгыг барих анхны зураг төсөвт тусгагдсаны дагуу 1119 м<sup>2</sup> явган хүний замыг хийж, 2018 онд хүлээлгэн өгсөн байхад 2019 онд ОНХС-аас хийсэн зам талбайн ажлын гүйцэтгэлд 250 м<sup>2</sup> явган зам талбайн ажлыг хийснээр гүйцэтгэл гаргасныг хянахгүй, санхүүжилтийг бүрэн олгосон.
- Эрдэнэ сумын Хүүхдийн цэцэрлэгийн гадна хашаа барих 20,8 сая төгрөгийн төсөвтэй ажлыг 2019.04.25-2019.05.25-ны хугацаанд гүйцэтгүүлэхээр СИЗУ ХХК-тай гэрээ байгуулж, гэрээг 2019.06.07-ыг хүртэл сунгаж, 2019.06.07-ны өдөр байгууламжийн ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гаргаж тус ажлыг хүлээн авсан байна. Ажлын тоо хэмжээнд 1,6 метр өндөртэй төмөр шонтой сараалжин хашаа, суурьтайгаа 2,3 метр хийхээр тусгасан байхад гүйцэтгэлийг үзэхэд 1,2 метрийн өндөртэй хашаа барьсан байна.

*ОНХС-аас зураг, төсөв, ТЭЗҮ боловсруулаагүйгээс ашиглах боломжгүй, үр дүнгүй ТАХ-г хэрэгжүүлсэн, мөн ТАХ-ний хэмжээний бодит гүйцэтгэлийг*

*үнэлэхгүйгээр санхүүжилт олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.*

➤ ХХАА-н сайд, Байгаль орчны сайд, СС-ын хамтарсан 2005 оны 101/189/194 тоот тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худагт, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ын Худагт, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, сонгоход тавигдах шаардлагын 3.2-т "Сэргээн засварлах, шинээр гаргахад орон нутгийн захиргаа, малчид, хоршоо хөрөнгө гаргана. Энэхүү оролцооны хөрөнгө нь худагт уст цэгийг сэргээн засварлах зардлын 10 хувиас доошгүй, шинээр барих зардлын 5 хувиас доошгүй байна" гэж заасан байна.

ОНХС-аас 2019 онд 4 суманд 179,8 сая төгрөгийн, 19 худаг шинээр гаргах ажлыг санхүүжүүлсэн байх бөгөөд дээрх журмын дагуу орон нутгийн малчид, иргэдээс оролцооны хөрөнгө болох 9,0 сая ба түүнээс дээш төгрөгийн хөрөнгийг бүрдүүлээгүй, энэ хэмжээгээр ОНХС-ийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

➤ ОНХС-аас хөдөөгийн сумдад хэрэгжүүлсэн ХО-ын ажлуудад мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүйгээс захиалагчийн хяналт чанартай хийгдээгүй, ажил хүлээж авах комисст мэргэжлийн бус, сумын ЗДТГ-ын албан хаагчид ажиллаж байгаагаас хөрөнгө оруулалтын ажлууд нь холбогдох норм дүрэм, чанарын баталгааг хангаагүй байна.

Аймгийн ГХБХБГ нь 2019 онд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, тус албаны 2 мэргэжилтэн, гэрээт 2 инженер, нийт 4 ажилтан орон нутагт УТХО, ОНТХО, ОНХС, бусад эх үүсвэрээр хийгдсэн 100 орчим хөрөнгө оруулалтын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн байгаа нь сумын ОНХС-аас хэрэгжүүлсэн ажлуудад захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхэд ажиллах хүчний тоо, цаг хугацаа, орон зайны хувьд нөхцөл бүрдээгүй байна.

### **Сайн жишээ:**

Дэлгэрэх сум ОНХС-аас 2019 онд гүний худаг гаргах, мал угаалгын ванн хийх зэрэг ажлуудыг гүйцэтгэхдээ малчдын оролцооны хөрөнгийг 50 хувь оролцуулан хямд өртгөөр гүйцэтгэсэн байна. Хэрэгжүүлсэн ажлын өртгийг бусад сумдад хийгдсэн ижил төрлийн ТАХ-ний өртөгтэй харьцуулж үзвэл 3 дахин бага төсвөөр хэрэгжүүлсэн, оролцооны хөрөнгө нийлүүлсэн ашиглагч иргэдээс ОНХС-аар хийгдсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад тавих хяналт сайжрах эерэг хандлага бий болж байна.

Энэ туршлагыг тайлант онд болон цаашид төв суурин газрын гэрэлтүүлэг, орон сууц, байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэдэх талбай, нийтийн эзэмшлийн газруудад хийгдэх ТАХ-д хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа нь сайшаалтай байна.

Аливаа төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийг оролцуулснаар бий болсон хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын асуудалд төрийн оролцоо багасаж, иргэдийн хяналт, оролцоо нэмэгдэх давуу талтай байна.

**2.2.3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 508.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын өмчид бүртгээгүй байна.**

МУ-ын Барилгын тухай хуулийн 35.1.4 “Аймгийн Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт байрлах барилга байгууламжийн ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”,

МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14.2.1-т “Төрийн байгууллага, албан газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах эрхтэй”;

Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 9.12 дахь заалтад “ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна” гэж тус тус заасан.

ОНХС-аас 2019 онд хэрэгжүүлсэн зарим ТАХ-г ашиглагч байгууллагууд өнөөдрийг хүртэл данс бүртгэлд тусгаагүй, захиалагч байгууллагаас ашиглалтад хяналт тавьж, бүртгэх, паспортжуулах үүргээ хэрэгжүүлээгүйгээс хөрөнгө эзэнгүйдэх, ашиглалт, хамгаалалтын асуудал орхигдсон байна. Тухайлбал:

- Хатанбулаг суманд 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг холбогдох байгууллагуудын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэхээр сумын ЗД-ын 2019.12.05-ны А/135 тоот захирамжаар захирамжилсан байна. Гэтэл 80,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй өмчлөлийн газарт хийсэн цахилгаан дамжуулах агаарын шугам, 19,8 сая төгрөгийн өртөгтэй Хилийн 0168 дугаар ангид байрлах тоглоомын талбай, 20,0 сая төгрөгийн төсөвтэй Цагдаагийн барилгын засвар, 15,5 сая төгрөгийн өртөгтэй Хилийн заставын гэрэлтүүлэг, нийт 135,3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгээгүй,
- Мөн 15,0 сая төгрөгийн төсөвтэй Хатанбулаг сумын ЕБС, цэцэрлэгийн худгийн цэвэршүүлэгчийг ашиглагч байгууллагын данс бүртгэлд тусгаагүй ЗДТГ-ын данс бүртгэлд бүртгэсэн,
- Хатанбулаг сумын ЭМТ-ийн 22,5 сая төгрөгийн цахилгааны монтажны засварын ажлыг хөрөнгийн сайжруулалтаар бүртгэсэн байна.
- Замын Үүд суманд хэрэгжүүлсэн 335.4 сая төгрөгийн, 6 ТАХ-г холбогдох байгууллагын данс бүртгэлд тусгаагүй байна.

*Дээр дурдагдсан 508.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын болон хамаарах хөрөнгийн данс бүртгэлд тусгуулахаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.*

Сумдад ОНХС-аас хэрэгжүүлж шинээр бий болсон хөрөнгийг ашиглагч улсын төсвийн байгууллагын хөрөнгөд бүртгүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар хариуцуулсан байх боловч МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11.8-д “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн ТЗБ-ын бүрэн эрхэд төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах

шийдвэр гаргах" гэж заасны дагуу ТӨБЗГ-т хөрөнгийг бүртгүүлэх хүсэлтийг явуулж, шийдвэр гарах хугацаанд тус хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтын асуудал орхигдож, хөрөнгө эзэнгүйдэх нөхцөл үүссэн байна.

**БҮЛЭГ 3. ОНХС-ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хугацаанд нь тайлагнасан ч, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс зөрчил давтагдан гарсан байна.**

**3.1. Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийсэн хяналт үр дүнгүй байна.**

**3.1.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хийх хяналтад иргэд, ИНБ-ын оролцоог хангаагүй байна.**

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-т ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ХО, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон тус журмын хэрэгжилтэд аймаг, сумын ИТХ-ын дэргэдэх хороо болон иргэд, ИНБ-ууд, бусад захиргааны байгууллагууд хяналт тавихаар тусгагдсан.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилтэд хяналт тавих хяналтын хороодыг сумдын ИТХ-аар томилсон байх боловч төлөвлөлт, санхүүжилтийн үе шатанд хяналт тавьж ажиллаагүй, гүйцэтгэлийн шатанд хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүй, мөн иргэд, ИНБ-ын төлөөллийг хяналт тавихад оролцуулаагүй, орон нутгаас боломжоор хангаж хамтарч ажиллаагүй байна. Зарим сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороодын хяналт хэрэгжүүлсэн баримт материалыг үзэхэд хяналт шалгалт хийсэн байдал, илрүүлсэн зөрчил, өгсөн зөвлөмж, оролцсон гишүүдийн талаарх мэдээлэл тодорхой бус байна.

Аймгийн ИТХ нь 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх хяналтын хороог байгуулаагүй байна.

ОНХС-ийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт, хэрэгжүүлсэн ТАХ-ны гүйцэтгэлд Айраг, Хатанбулаг, Мандах сумд ИТХ-ын дэргэдэх хяналтын хороонд багийн дарга нар, ард иргэдийн төлөөллийг оролцуулан хяналтыг чанартай хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Айраг сумын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороо нь ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ТАХ-ны гүйцэтгэлийн явц, ашиглалтад орон нутгийн иргэдийг оролцуулан 3 удаагийн хяналтыг хэрэгжүүлж, тухай бүр зөвлөмжийг гүйцэтгэгч болон захиалагчид өгч ажилласан ба хэрэгжилт хангагдахгүй байгаа ажлуудын талаар аймгийн ИТХ-д 2020 онд албан бичгийг хүргүүлсэн байна.
- Хатанбулаг суманд ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлсэн нийт ажлын гүйцэтгэлд хяналт хийлгүүлэхээр сумын ИТХ-ын даргын А/12 тоот захирамжаар ашиглагч байгууллагуудын төлөөллийг хамруулсан 14 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулан хяналтыг хэрэгжүүлсэн байна.
- Мандах сумын ИТХ-ын 17 дугаар тогтоолоор ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж, ОНХС-аас хийгдсэн ТАХ-ны явц, гүйцэтгэлд

иргэдийн төлөөлөл болон багийн дарга нарыг хамруулан хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас Алтанширээ, Айраг, Өргөн, Эрдэнэ сумдын ОНХС-ын 2019 оны үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлж, шалгалтаар ИТХ-аар зураг, төсөл, эдийн засгийн тооцоогүй ажлуудыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж баталсан, ИТХ нь хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг өөрчилсөн, ажил гүйцэтгэх гэрээний биелэлтэд тавих хяналт сулаас магадалшгүй ажлын зардал, зураг төслийн үнийг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн, их засварын ажлууд чанаргүй хийгдсэн, ОНХС-аар хийгдсэн төсөл арга хэмжээг шалгаруулах үйл ажиллагаанд ард иргэдийн иргэдийн оролцоог хангаагүй, саналыг бүрэн тусгаагүй зэрэг зөрчил дутагдал илрүүлж, давхардсан тоогоор 23 аж ахуйн нэгжтэй холбоотой 8332,2 мянган төгрөгийн төлбөр зөрчилд улсын байцаагчийн 4 төлбөрийн акт тогтоосон байна.

Хөдөө орон нутагт тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоо, засаглалыг сайжруулах зорилго бүхий Тогтвортой амьжиргаа-3 төсөл нь ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнг хянах системийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд Дорноговь аймгийн ОНХС-ийн 2019 оны жилийн гүйцэтгэлд үнэлгээ хийсэн байна.

Тус үнэлгээгээр 2019 онд Дорноговь аймгийн нийт сумдын дундаж үнэлгээ 59,4 хувьд хүрсэн нь улсын дундаж үзүүлэлтээс 20 орчим хувиар өндөр, харин өмнөх жилийн үнэлгээнээс буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Өмнөх оны дүнтэй харьцуулахад аймгийн хэмжээнд ИНХ-д иргэдийг оролцуулсан байдал буурч, шилэн дансанд мэдээлэл оруулсан байдал болон ОНХС-ийн тайлан мэдээ гаргах байдал сайжирсан байна.

Харин сумдын хувьд олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах, өмчийн удирдлагын үзүүлэлтээр Дэлгэрэх, төлөвлөлтийн үзүүлэлтээр Иххэт, гүйцэтгэлийн үзүүлэлтээр Эрдэнэ, хяналт шинжилгээ үнэлгээгээр Мандах сум өндөр үнэлгээ авч, Сайншанд, Улаанбадрах, Хөвсгөл, Сайхандулаан сумдын үнэлгээ буурч, дараагийн жилд урамшуулал олгохооргүй үнэлэгдсэн байна.

**3.1.2. ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн хяналт, шинжилгээ үнэлгээний ажил хангалтгүй хийгдэж байгаагаас сангийн үйл ажиллагааны үр дүн сайжрахгүй байна.**

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан ОНХС-ийн үйл ажиллагааны журамд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ны төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналтад бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт шинжилгээг аймаг, сумын захиргааны байгууллагууд хийж, тайлан, дүгнэлт, зөвлөмжийг ОНХС-ийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэх үүргийг аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ, сумын ЗДТГ хүлээхээр тусгасан байна.

Аймгийн ЗДТГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу ХШҮДАХ-ээс ОНХС-ийн 2019 оны хөрөнгө оруулалтаар зөвхөн аймагт хэрэгжүүлсэн ТАХ-ний төлөвлөлтөд орон нутгийн иргэдийн өгсөн санал, эрэмбэлэлт, хэрэгжүүлсэн ТАХ нь аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, ЭЗН-ийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдсан байдал, томилогдсон ажлын хэсгийн ажилласан байдалд

хяналт шалгалтыг хэрэгжүүлж, тус хяналтаар зөрчил илрээгүй, энэ талаар олон нийтэд мэдээлэх үүргээ хангаж ажиллаагүй байна.

Нийт сумдаас аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т ирүүлсэн хяналт шинжилгээний үнэлгээний тайлангаас харахад Сайншанд, Айраг сумд ОНХС-аас хэрэгжүүлсэн ТАХ-ний үр дүнд үнэлгээ өгсөн бусад сумд ХАА-ны тайланг ирүүлсэн байна.

### **3.2. ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийн явцыг хугацаанд нь тайлагнаж, хүргүүлсэн байна.**

#### **3.2.1. ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг Төсвийн тухай хууль болон журам, зааварт тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.**

ОНХС-ийн үйл ажиллагааны журам"-ын 9.1-т "... сумын санхүүгийн алба нь ОНХС-ийн төсвийн гүйцэтгэлийн тайланг энэ журмын 10 дугаар хавсралтад заасны дагуу аймгийн СТСХ-т Төсвийн тухай хуульд заасан санхүү, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах хугацаанд тайлагнана", 9.2-т сумын ЗДТГ-ын дарга нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжиж буй ХО, ТАХ-ний хэрэгжилтийн тайланг гаргаж, дараа оны 02 дугаар сарын 01-ний дотор аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлнэ" гэж заасан.

Дээрх заалтын дагуу нийт 14 сумаас 2019 оны ОНХС-ийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланг холбогдох хавсралт маягтаар аймгийн СТСХ-т ирүүлж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ээс аймгийн, СТСХ-ээс сумдын ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн тайланг хугацаанд нь гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн байна.

#### **3.2.2. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 92,4 хувьтай байна.**

ОНХС-ийн 2018 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд дараах байдалтай байна.

#### **Өмнөх оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая.төгрөг/**

/Хүснэгт №4/

| Үзүүлэлт        | Тогтоосон |               |  | Хэрэгжсэн |               | Хэрэгжээгүй |              | Хэрэгжилтийн хувь |
|-----------------|-----------|---------------|--|-----------|---------------|-------------|--------------|-------------------|
|                 | Тоо       | Дүн           |  | Тоо       | Дүн           | Тоо         | Дүн          |                   |
| Зөвлөмж         | 8         | 2750,3        |  | 7         | 2548,3        | 1           | 202,0        | 92,7              |
| Албан шаардлага | 4         | 176,8         |  | 3         | 156,8         | 1           | 20,0         | 88,7              |
| Төлбөрийн акт   | 4         | 1,4           |  | 3         | 1             | 1           | 0,4          | 71,4              |
| <b>Дүн</b>      | <b>16</b> | <b>2928,5</b> |  | <b>13</b> | <b>2706,1</b> | <b>3</b>    | <b>227,8</b> | <b>92,4</b>       |

Өмнөх онд ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар ОНХС-ийн 2018 оны үйл ажиллагааны үр дүн сэдэвт НА-ыг 2019 оны 4 дүгээр сард гүйцэтгэж, аудитаар 1,4 сая төгрөгийн 4 акт, 176,8 сая төгрөгийн 4 албан шаардлага, 2750,3 сая төгрөгийн 8 зөвлөмж хүргүүлсэн байна.

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг авч үзэхэд 0.4 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 20,0 сая төгрөгийн 1 албан шаардлага, 202,0 сая төгрөгийн 1 зөвлөмж тус тус хэрэгжээгүй ба хэрэгжилтийг ирүүлэх хугацаа хэтэрсэн байна.

Өмнөх онд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн нийт хэрэгжилт 92,4 хувьтай байна.

Хэрэгжээгүй төлбөрийн актын үлдэгдлийг авч үзэхэд Иххэт сумын ОНХС-ийн 2018 оны хөрөнгөөр “Сумын төвийн ундны усны нөөц тогтоох” ажлыг Уотер голд дриллинг ХХК-аар гүйцэтгүүлэхдээ захиалагчийн хяналтын зардлыг илүү шилжүүлснээс үүссэн байх ба тус актыг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгч компанийг цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна.

Мандах сумын ОНХС-ийн 2018 оны хөрөнгөөр “Сумын төвийн хогийн цэг хашаажуулах ажил”-ыг гүйцэтгэсэн Мандах иргэдийн бүлэг нь хог шатаах зуухыг хийгээгүй байсан зөрчилд албан шаардлага өгсний дагуу гэрээнд тусгагдсан дутуу ажлыг гүйцэтгүүлж эхэлсэн боловч өнөөдрийг хүртэл хэрэгжилтийг бүрэн гаргаж ирүүлээгүй байна.

Замын Үүд сумын холбогдох албан тушаалтнуудад ТЭЗҮ-тэй ТАХ-г төлөвлөх болон зориулалт бусаар сангийн хөрөнгийг зарцуулсан зөрчилд ОНХС-ийн хөрөнгийг хууль, журмын дагуу төлөвлөж, зарцуулах талаар зөвлөмж хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл хэрэгжилтийг гаргаж ирүүлээгүй байна.

**3.2.3. Иргэдийн санал, оролцоонд үндэслэн ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөж байгаа үйл явц нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгыг бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлээгүй байна.**

ОНХС-ийн үйл ажиллагааны журамд ОНХС-ийн зорилго нь орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ гэж заасан.

➤ Дээрх зорилгыг хэрэгжүүлэх үүднээс иргэдийн оролцоотойгоор уг сангаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-г төлөвлөх талаар МУ-ын Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн үйл ажиллагааны журамд тодорхой зааснаар иргэд өөрсдийн амьдрах таатай орчноо бүрдүүлэхийн тулд ОНХС-ийн хөрөнгөөр бүтээн байгуулах, хэрэгжүүлэх аливаа хөтөлбөр, ТАХ-д саналаа өгөх, бүтээлчээр оролцох, хамтарч ажиллах боломж нь эрх зүйн хувьд нээлттэй болсон байна.

Гэвч орон нутгаас хөгжлийн талаарх баримталж байгаа бодлого чиглэл, хэрэгжүүлсэн ажил, ОНХС-ийн үйл ажиллагааны төлөвлөлт, зарцуулалт, тайлагналд оролцох оролцооны талаарх иргэдийн хууль зүйн мэдлэг тааруу, иргэдээс гаргаж байгаа санал нь орон нутгийн хөгжилд чиглэгдээгүй, сумын хөгжлийн бодлого, чиглэлтэй уялдаагүй, иргэдийн амьдралд гарах өөрчлөлт, үр өгөөжийг тооцоогүй, зөвхөн тухайн иргэнд чиглэгдсэн байгаагаас ОНХС-ийн

хөрөнгийг иргэдийн саналд үндэслэн, үр ашигтай, хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг санхүүжүүлэх нөхцөл бүрдэхгүй, ОНХС-ийн зорилго хангагдахгүйд хүрч байна.

➤ МУ-ын Сангийн сайдын 2012 оны 43 дугаар тогтоолоор ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, сумын хэмжээнд хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүдийг тодорхой заасан байсныг СС-ын 2018 оны 228 дугаар тушаалаар шинэчлэн батлахдаа тодорхой бус болгосноос сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхгүй чиг үүргүүдийг хэрэгжүүлж, сангийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан байна.

➤ ОНХС-ийн үйл ажиллагааны шинэчлэгдсэн журамд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ХО, ТАХ-ны төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна гэж тусгасан байгаа нь ОНХС-ийн үйл ажиллагааг шат шатанд гардан гүйцэтгэж, зөрчил гаргасан албан хаагчдад хүлээлгэх хариуцлагын асуудал орхигдсон, хяналт шалгалтаар өмнө нь гарсан зөрчил дутагдлууд давтагдан гарсаар байна.

Сумын Засаг даргын орлогчийн албан тушаалын тодорхойлолтын үндсэн зорилтын хүрээнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх, гүйцэтгэх, хянах, хүлээн авах бүх шатны ажлыг хариуцан ажиллахаар тусгагдсаны дагуу ажлын үндсэн чиг үүргээс гадна ОНХС-ийн төлөвлөлт, тендер шалгаруулалт, хяналт хийх, ТАХ-г хүлээн авах ажлуудыг бүх шатанд хариуцан хэрэгжүүлж байгаа нь ажлын ачааллын хувьд харилцан адилгүй байна.

Гэтэл ОНХС-ийн үйл ажиллагааг хамтран гүйцэтгэж байгаа багийн Засаг дарга, ИНХ, сумын Засаг дарга, ИТХ, ЗДТГ, санхүүгийн албаны хүлээх үүрэг хариуцлага харилцан адилгүй байгаа бөгөөд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлийг сайжруулах, үр дүнд хүргэх шаардлагын хүрээнд тус сангийн үйл ажиллагааг тусгайлан хариуцсан албан тушаалтан байх шаардлагатай байна.

➤ ОНХС-ийн үйл ажиллагааны шинэчлэгдэн батлагдсан журмын 9.12-т "ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн ХО-ын үр дүнд бий болсон барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хуульд заасны дагуу өмчлөлд бүртгэж, авсан байгууллага нь ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зардлыг хариуцна" гэж заасан.

Гэтэл сумдад ОНХС-аас хэрэгжүүлж шинээр бий болсон хөрөнгийг ашиглагч улсын төсвийн байгууллагын хөрөнгөд бүртгүүлэхээр сумын Засаг даргын захирамжаар хариуцуулсан байх боловч МУ-ын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу ТӨХ-д хөрөнгийг бүртгүүлэх хүсэлтийг явуулж, шийдвэр ирүүлтэл тус хөрөнгийн бүртгэл, хадгалалт, хамгаалалтын асуудал орхигдож, хөрөнгө эзэнгүйдэх нөхцөл үүссэн байна.

## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

- ОНХС-ийн эх үүсвэрийг төлөвлөхдөө гадаад, дотоодын хандив, тусламжийн орлогыг боломжит хэмжээгээр төлөвлөөгүй, зарим сумд хандив тусламжийн орлогыг ОНХС-д төвлөрүүлэхгүй зарцуулсан байна.
- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын төлөвлөгөө биелээгүйгээс ОНХС-аас аймгийн ОНХС-д 1251,8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг дутуу олгосон байна.
- Аймаг, сумын түвшинд ОНХС-ийн үйл ажиллагааг төлөвлөхөд өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, аймаг, сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой ХО, ТАХ-ний танилцуулгыг бэлтгэж, мэдээ мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд танилцуулах, иргэдэд мэдээлэл хүргэх ажил хангалтгүй хийгдсэнээс иргэд орон нутгийн хөгжлийг дэмжсэн, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад чиглэсэн, нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ТАХ-ний талаар саналд тусгадаггүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд 6725,4 сая төгрөгийн өртөгтэй, 128 ТАХ-ний ХАА зохион байгуулсны 95 ХАА буюу 74,2 хувийг хөдөөгийн сумдад зохион байгуулсан байх ба үнэлгээний хорооны гишүүдийн ур чадвар, зохион байгуулалтын асуудлаас шалтгаалж ТББ-ийг хангалтгүй боловсруулсан, тендерт оролцогчдын өрсөлдөх боломжийг хязгаарласан, ТЭЗҮ, зураг, төсөвгүй ТАХ-ний ХАА-г зохион байгуулсан байна.
- ОНХС-аас хэрэгжүүлсэн ТАХ-ний бодит гүйцэтгэлийг хянахгүйгээр 330,4 сая төгрөгийн, 9 ТАХ-г санхүүжүүлж, тус сангийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулсан байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр 2019 онд МУ-ын Төсвийн тухай хуулиар зарцуулахыг хориглосон чиг үүргийн буюу иргэдийн саналд тусгаагүй, нийтийн эрх ашигт нийцээгүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлуулаагүй зэрэг 1226,6 сая төгрөгийн, 68 ТАХ-г санхүүжүүлсэн байна.
- ОНХС-аас хөдөөгийн сумдад хэрэгжүүлсэн ХО-ын ажлуудад мэргэжлийн байгууллагаас хяналт хэрэгжүүлээгүйгээс захиалагчийн хяналт чанаргүй хийгдсэн, ажил хүлээж авах комисст мэргэжлийн бус албан хаагчид ажилласнаас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний чанар байдалд нөлөөлсөн байна.
- Орон нутагт инженерийн хийцтэй худагт, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргахад орон нутгийн захиргаа, малчид, хоршоо оролцооны хөрөнгийг гаргахаар заасан ч журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 508.2 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгах ажил орхигдсон байна.
- Аймгийн ИТХ нь 2019 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх хяналтын хороог

байгуулаагүй, сумдын ИТХ-аар хяналтын хороодыг томилсон байх боловч төлөвлөлт, санхүүжилтийн үе шатанд хяналт тавьж ажиллаагүй, гүйцэтгэлийн шатанд хяналт хангалтгүй хэрэгжсэн байна.

- ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний ажил аймгийн хэмжээнд хангалтгүй хийгдэж байгаагаас тус сангийн үйл ажиллагааны үр дүн дээшлээгүй, өмнө аудитаар илрүүлсэн зөрчил давтагдсан гарсан байна.
- Өмнө онд ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийгдсэн аудитаар төлөвлөгөөнд орон нутгийн хөгжилд чиглэсэн, зураг, төсөв батлагдсан, ТЭЗҮ хийгдсэн, иргэдийн саналд тусгагдаж эрэмбэлэгдсэн, орон нутгийн төсөвт тусгаж батлагдсан ТАХ-г хэрэгжүүлэх талаар зөвлөмжийг өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй, зөрчил давтагдсан байна.

Аудитаар нийт 33439.9 сая төгрөгийн зөрчил илрүүлж, чанаргүй хийгдсэн ажлыг дахин гүйцэтгүүлэх, зөрчил давтан гаргахгүй байх8 хөрөнгө данс бүртгэлд бүртгэх тухай 508.2 сая төгрөгийн 14 албан шаардлага бичиж, холбогдох албан тушаалтнуудад 12 зөвлөмжийг хүргүүллээ.

## ЗӨВЛӨМЖ

### Аймгийн ИТХ-д:

1. ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.4-т заасны дагуу аймгийн ИТХ-ын дэргэдэх хяналтын хороог томилж, тус сангийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон журмын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажиллах.

### Аймгийн Засаг даргад:

Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 11.1 “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн ХО, ТАХ-ний төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, тайлагналт, бүртгэл, хяналт болон эцсийн үр дүнг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна” гэсэн заалтын дагуу дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. МУ-ын Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журамд заасан ОНХС-ийн эх үүсвэрийг бүрэн төлөвлөх.
2. Сангийн Сайдын 2016 оны 17 тоот тушаалаар батлагдсан журамд заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн орлогын гүйцэтгэлийн мэдээллийг улирал бүр авч, хяналт тавин, орлогын төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтарч ажиллах.
3. Аймгийн ОНХС-аас хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ХО, ТАХ, өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой ХО, ТАХ-ний танилцуулгыг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тогтмол танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулж, ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог бүрэн хангаж ажиллах.
4. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ХО, ТАХ-г олон нийтийн оролцоотой төлөвлөх, арга зүйн зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг чадавхжуулах, ОНХС-ийн төлөвлөлтийг чанартай хийх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.
5. Хөдөөгийн сумдад ОНХС-аас хэрэгжиж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагын оролцоотой хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, холбогдох байгууллага, хэлтсээс мэргэжил арга зүйгээр тогтмол хангаж ажиллах.
6. ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу хяналт шинжилгээ, үнэлгээг үр дүнд чиглүүлэн чанартай хийж, сангийн төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд давтагдан гарсаар байгаа зөрчил дутагдлыг арилгах дүгнэлт, зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэн, хэрэгжилтийг хангуулж ажиллах.


### **Сумдын ИТХ-д:**

1. Сумдын ИТХ-ын хяналтын хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, тус сангийн төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон журмын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлж ажиллах.

### **Сумдын Засаг дарга нарт:**

1. Сумын ОНХС-аас хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ХО, ТАХ, өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, сумын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой ХО, ТАХ-ний танилцуулгыг мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тогтмол танилцуулах, сурталчлах ажлыг зохион байгуулж, ОНХС-ийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог бүрэн хангаж ажиллах.
2. Сумдын үнэлгээний хороо, ажлын хэсэгт ажиллаж байгаа бүрэлдэхүүнийг чадавхжуулах, сургалтад хамруулах талаар бодлого барьж, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллаж, зөвлөгөө зөвлөмжөөр тогтмол хангаж, ОНХС-ийн төлөвлөлтийг чанартай хийх нөхцөлийг бүрдүүлж ажиллах.
3. Худаг, уст цэгийг шинээр барих, сэргээн засварлахад малчид, иргэдээс оролцооны хөрөнгийг төвлөрүүлж, ОНХС-ийн эх үүсвэрт тусгаж төлөвлөх.
4. ОНХС-аас хэрэгжүүлж байгаа ТАХ-ний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх болон ажил хүлээн авах ажлын хэсэгт мэргэжлийн байгууллагын холбогдох ажилтнуудыг татан оролцуулах боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн байгууллага, холбогдох хэлтсээс мэргэжил арга зүйн зөвлөгөө авч, уялдаа холбоотой ажиллах.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ



### ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг,  
Нутгийн удирдлагын ордон, Утас/Факс: (976) 7052 3036,  
И-мэйл: zdtg@dornogovi.gov.mn, Вэбсайт: dornogovi.gov.mn

2020.11.12 № 3/1549  
танай 2020.11.10 -ны № 1-6/769 -т

### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын 2020 оны 1-6/769 тоот албан бичгээр ирүүлсэн Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТХР ОВЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

У.ГАНБААТАР



44 8201959  
D:\2020\ZAH-TOOT

**АУДИТЫГ ГҮЙЦЭТГЭСЭН БАГИЙН ГИШҮҮД:**

**ГҮЙЦЭТГЭСЭН:**

АХЛАХ АУДИТОР



Э.ЭНХЦЭЦЭГ

АУДИТОР



Л.РАВДАНДОРЖ


**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР




Ч.ХЭРЛЭНЧИМЭГ

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА



АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХАМТРАН ОРОЛЦСОНД  
ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛБЕ.

## ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2020 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/17


Дорноговь аймаг, Сайншанд сум

#### Нийцлийн аудитын тайлан баталгаажуулах тухай

Монгол Улсын Төрийн Аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.2, 20.3, 21 дүгээр зүйлийн 21.1, МУ-ын Ерөнхий аудиторов 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "ТАБ-ын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам", 2016 оны А/146 тоот тушаалаар батлагдсан "Нийцлийн аудитын түр журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалт, 2018 оны А/207 тоот тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт" сэдэвт нийцлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлагуудыг хавсралтаар баталсугай.
3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, үр дүнг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг аймаг, сумдын Засаг дарга, ИТХ-ын дарга нарт тус тус зөвлөсүгэй.
4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймаг, сумдын Засаг дарга болон ИТХ-ын дарга нарт тус тус хүргүүлсүгэй.
5. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Ч.Хэрлэнчимэг/-т даалгасугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

• 1/0010020

Дорноговь аймаг дахь Төрийн аудитын  
газрын дарга, тэргүүлэх аудиторын 2020  
оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/У/Т  
тоот тушаалын хавсралт

“ОНХС-ийн 2019 оны үйл ажиллагааны хэрэгжилт”  
сэдэвт нийцлийн аудитаар өгсөн  
албан шаардлагын жагсаалт

4417144353  
ЕЮА0056 9025707

| Д/д      | Албан шаардлагын дугаар | Албан шаардлагын агуулга                         | Мөнгөн дүн /сая.төгрөг/ | Хэрэгжүүлэх албан тушаалтан                                                                                                                                |
|----------|-------------------------|--------------------------------------------------|-------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1        | 01/110 ДГА-2020/07-НА   | Чанаргүй хийгдсэн ажлыг дахин гүйцэтгүүлэх тухай | 0                       | Хөвсгөл сумын Засаг дарга Н.Энхбаяр<br>ЗД-ын орлогч Г.Ганболд<br>ЗДТГ-ын дарга Ц.Март                                                                      |
| 2        | 02/111 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Даланжаргалан сумын ЗД С.Уранцэцэг<br>ЗД-ын орлогч Д.Өлзийсаран<br>ЭМТ-ийн дарга Ө.Бямбажав                                                                |
| 3        | 03/112 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Эрдэнэ сумын ЗД Э.Ганбаяр<br>ЗД-ын орлогч Б.Буянбаатар<br>ЗДТГ-ын дарга Г.Алтанцацрал                                                                      |
| 4        | 04/113 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Хатанбулаг сумын ЗД С.Эрдэнэболд<br>СА-ны дарга Т.Ууган Эрдэнэ<br>ЗДТГ-ын дарга Т.Цэцэгсүрэн                                                               |
| 5        | 05/114 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Айраг сумын ЗД Л.Мөнхжаргал<br>ЗД-ын орлогч Б.Амгаланбаатар<br>ЗДТГ-ын дарга А.Эрдэнэтуяа                                                                  |
| 6        | 14/123 ДГА-2020/07-НА   | Хөрөнгийг данс бүртгэлд тусгуулах тухай          | 172,8                   | Хатанбулаг сумын ЗД С.Эрдэнэболд<br>СА-ны дарга Т.Ууган Эрдэнэ<br>ЭМТ-ийн дарга Г.Цэемаа<br>ЕБС-ийн захирал Т.Намжилмаа<br>Цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунцэцэг |
| 7        | 06/115 ДГА-2020/07-НА   |                                                  | 335.4                   | Замын Үүд сумын ЗД Н.Алдарбаяр<br>ХОХБТ-ийн дарга Н.Алтангэрэл<br>Нягтлан бодогч Н.Тунгалаг                                                                |
| 8        | 07/116 ДГА-2020/07-НА   | Зөрчил давтан гаргахгүй байх                     | 0                       | Хөвсгөл сумын Засаг дарга Н.Энхбаяр<br>ЗД-ын орлогч Г.Ганболд<br>СА-ны дарга У.Баярмаа                                                                     |
| 9        | 08/117 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Хатанбулаг сумын ЗД С.Эрдэнэболд<br>СА-ны дарга Т.Ууган Эрдэнэ                                                                                             |
| 10       | 09/118 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Замын Үүд сумын ЗД Н.Алдарбаяр<br>ЗАА-ны дарга Ц.Саруулсайхан<br>СА-ны дарга Ш.Сувд Эрдэнэ                                                                 |
| 11       | 10/119 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Эрдэнэ сумын ЗД Э.Ганбаяр<br>СА-ны дарга Ч.Өлзиймөнгө                                                                                                      |
| 12       | 11/120 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Айраг сумын ЗД Л.Мөнхжаргал<br>ЗД-ын орлогч Б.Амгаланбаатар<br>СА-ны дарга Б.Цэрэндолгор                                                                   |
| 13       | 12/121 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Алтанширээ сумын ЗД Л.Цэцэгдарь<br>ЗД-ын орлогч М.Мөнхтулга<br>СА-ны дарга П.Наранцэцэг                                                                    |
| 14       | 13/122 ДГА-2020/07-НА   |                                                  | 0                       | Дэлгэрэх сумын ЗД Д.Дулам<br>ЗД-ын орлогч Р.Сосорбарам<br>СА-ны дарга Б.Чимэдрэгзэн                                                                        |
| Нийт дүн |                         |                                                  | 508.2                   |                                                                                                                                                            |

-----oOo-----